



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР
БОДЛОГОД ОРОЛЦОГЧ,
ШИНЖЭЭЧДЭЭС АВАХ
СУДАЛГАА” – НЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот, 2024 он

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДЭЭС АВАХ СУДАЛГАА” – НЫ ТАЙЛАН

Захиалагч: Авлигатай тэмцэх газар
Гүйцэтгэгч: “Бодлогын шийдэл” ТББ

Улаанбаатар хот, 2024 он

Энэхүү тайлан нь “Шударга байдлын үнэлгээ – 2024” судалгааны “Төрийн байгууллагын шударга байдлын талаар Бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгаа”-ны тайлан юм.

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг АТГ-аас хараат бус байдлаар гүйцэтгэсэн бөгөөд “Бодлогын шийдэл” ТББ-аас явуулсан судалгаанд оролцогчдын үнэлгээний үр дүнд үндэслэгдсэн болно.

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Доктор Ж.Баттулга

Тайлан боловсруулсан: Доктор Ө.Амар

Мэдээлэл цуглуулалтын баг:

Э.Алигармаа
Б.Ариунболд
Ө.Амар
С.Акерке
Г.Анудагий
С.Алданыш
И.Батхишиг
Т.Баяржаргал
Б.Болорням
З.Боргил
Л.Буд
Г.Бадамцэцэг
М.Булганхангай
Л.Баярцэцэг
Б.Буяндэлгэр
Б.Гантөмөр
Д.Дэлгэрцэцэг
Г.Оюун-Эрдэнэ
Г.Ундрах
Б.Нарантуяа
З.Сайнжаргал
И.Мандат
Д.Итгэлмаа
Е.Кумисай
Д.Маралмаа
П.Мөнгөнцэцэг
С.Мөнх-Од
Т.Тасилима
Б.Энхжин
Н.Эрдэнэцэцэг

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	iii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	iv
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	v
ТАЛАРХАЛ	vi
ХУРААНГУЙ	1
БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ.....	4
1.1 Шударга байдлын үнэлгээний аргачлал	4
1.1.1 Үнэлгээний загвар.....	4
1.1.2 Үнэлгээний утга.....	4
1.2 Судалгааны хамрах хүрээ	5
1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	6
БҮЛЭГ 2. БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	7
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл.....	7
2.2 Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээний ерөнхий үр дүн	7
2.2.1 БОУ хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд.....	9
2.2.2 Яамдын бодлогод оролцогчдын үнэлгээ	10
2.2.3 Агентлагуудын бодлогод оролцогчдын үнэлгээ	12
2.2.4 Аймаг, нийслэлийн бодлогод оролцогчдын үнэлгээ	14
2.2.5 Дүүргүүдийн бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн	16
2.3 Бодлогод оролцогчдын үнэлгээний дэд үзүүлэлтийн үр дүн.....	17
2.4 БОУ гүйцэтгэл бага байгууллагууд	22
2.4.1 Хамгийн бага үнэлгээ бүхий байгууллагууд	22
БҮЛЭГ 3: МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ	31
3.1 Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал	31
3.2 Монгол улс дах авлига хамгийн их тархсан институц	31
3.3 Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан нөхцөл.....	33
3.4 Ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл	34
3.5 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ	35
ДҮГНЭЛТ	36
ХАВСРАЛТ	39

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг ШБҮ-ний 0-100 оноонд шилжүүлэх.....	5
Хүснэгт 2. Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчийн төлөөлж буй хүрээ	7
Хүснэгт 3. БОҮ, хамгийн өндөр болон хамгийн бага оноо авсан байгууллагууд..	9
Хүснэгт 4. БОҮ, хамгийн өндөр оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ.....	10
Хүснэгт 5. БОҮ, хамгийн бага оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ.....	10
Хүснэгт 6. Яамдын БОҮ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар	10
Хүснэгт 7. Агентлагуудын БОҮ, 2023, 2024 оны харьцуулсан байдлаар	12
Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОҮ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар	15
Хүснэгт 9. Дүүргүүдийн БОҮ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар.....	16
Хүснэгт 10. Яамдын БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал.....	19
Хүснэгт 11. Агентлагуудын БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал	19
Хүснэгт 12. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал.....	21
Хүснэгт 13. Дүүргүүдийн БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал	21
Хүснэгт 14. БОҮ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, байгууллагын төрлөөр, 2023 онтой харьцуулсан байдал (нэгтгэсэн)	22
Хүснэгт 15. Үндэсний геологийн албын БОҮ-ний дэд үзүүлэлт, түүний өөрчлөлт	23
Хүснэгт 16. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт.....	25
Хүснэгт 17. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт	26
Хүснэгт 18. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОҮ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт.....	28
Хүснэгт 19. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын БОҮ, түүний дэд үзүүлэлтүүд.....	29
Хүснэгт 20. Монгол улсад авлига хамгийн их тархсан институц, хариултад эзлэх хувиар.....	32
График 1. БОҮ, оноогоор, байгууллагын төрлөөр	8
График 2. БОҮ, дэд үзүүлэлтээр, оноор	17
График 3. БОҮ-ний дэд үзүүлэлт, байгууллагын төрлөөр, 2024 он.....	18
График 4. Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, хувиар.....	31
График 5. Бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд авлигыг бууруулах, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлс	32
График 6. Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан, нөхцөл, хариултад эзлэх хувиар.....	34
График 7. Ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх төсөөлөл.....	35
График 8. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар.....	35

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ- Авлигатай тэмцэх газар

БОҮ- Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ

ЗДТГ- Засаг даргын тамгын газар

ЭБАТ- Эрх бүхий албан тушаалтан

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

“Авлига” гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг
“Шударга байдлын үнэлгээ” гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээг

“Шударга байдлын үнэлгээний судалгаа” гэж гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээг хийхээр зохион байгуулж буй судалгааны нийлбэр цогцыг

“Бодлогод оролцогчдын үнэлгээ” гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг

“Төрийн үйлчилгээ” гэж төрийн байгууллага, төрийн албан хаагчаас хууль тогтоомжид заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд иргэд, бусад байгууллагад үзүүлж буй аливаа үйлчилгээг тус ойлгох юм.

ТАЛАРХАЛ

“Төрийн байгууллагуудын шударга байдлын талаар бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгаа” – ны ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож судалгааны арга зүйн зөвлөгөө өгсөн “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олонд, мөн судалгааны тоон мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд, судалгааны тоон мэдээлэл цуглуулалтад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье.

ХУРААНГУЙ

“Авлигатай тэмцэх газар” нь 2015 оноос эхлэн Төрийн байгууллагуудын “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгааг зохион байгуулж ирсэн бөгөөд энэхүү судалгааны нэг хэсэг нь Төрийн байгууллагуудын бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ юм. Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээг авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдлын 11 үзүүлэлт (төрийн албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал, нэмэлт төлбөр болон бэлэг, хандив, санхүүгийн тусламж, үнэ бүхий зүйл өгсөн талаар сонссон болон бусдаас авсан талаар сонссон байдал), авлигыг хянах механизмын 3 үзүүлэлт (авлигыг дотоод механизмаараа илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, шударга ёсыг бэхжүүлэх авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан байдлын үр дүн), удирдлагын хүсэл эрмэлзлийн 2 үзүүлэлт (удирдлагын болон дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл) нийт 3 бүлгийн 16 үзүүлэлтээс бүрддэг.

2024 оны Төрийн байгууллагуудын шударга байдлын судалгаанд яам, агентлагууд, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-уудын бодлогод оролцогч 1530 шинжээчдийн хамруулсан бөгөөд нийт бодлогод оролцогч, шинжээчдийн 33.3 хувийг төрийн албан хаагч, 20.3 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 18.4 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.2 хувийг эрдэмтэн, судлаачид, 6.2 хувийг бодлого боловсруулагч, 5.1 хувийг хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.4 хувийг аудитор, хяналтын ажилтан, 5.1 хувийг бусад салбарын төлөөлөл тус тус эзэлж байна.

БОУ нь 2024 онд 67.1 болж, 2023 онтой харьцуулахад 6.6 оноогоор буурч үнэлэгджээ. БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 7.9 оноогоор, авлигыг хянах механизм 6.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.6 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс төрийн байгууллагуудын авлигын бодит тохиолдол хамгийн их оноогоор буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Байгууллагын төрлөөр БОУ-г авч үзвэл яамдын БОУ нь 68.6 оноо болж, 2023 онтой харьцуулахад 8.7 оноогоор, агентлагуудын БОУ нь 69.9 оноо болж, 2023 онтой харьцуулахад 5.4 оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ нь 62.2 оноо болж, 2023 онтой харьцуулахад 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. Яамдын БОУ буурч үнэлэгдэхэд яамдын авлигын талаарх төсөөлөл 10.6 оноогоор, авлигыг хянах механизм 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 6.7 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Агентлагуудын БОУ нь бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад хамгийн өндөр буюу 69.9 байгаа бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ нь хамгийн бага буюу 62.2 байгаагаас харахад Төрийн байгууллагуудын шударга байдал нэгж түвшинд “Бага” байдаг нь харагдаж байна.

БОУ-ээр “Хууль зүй дотоод хэргийн яам” 2024 онд нэгдүгээрт эрэмбэлэгдсэн бол, “Говьсүмбэр аймгийн ЗДТГ”-ын үнэлгээ хамгийн бага үнэлэгдсэн байна. Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн “Хууль зүй дотоод хэргийн яам”-ны хувьд 2023 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл хамгийн ихээр сайжирсан бол, тус байгууллагын авлигын бодит тохиолдол хэвээр байсан гэж бодлогод оролцогчид үнэлжээ. Хамгийн бага оноо авсан “Говьсүмбэр аймгийн ЗДТГ”-ын хувьд 2023 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл 38.3 оноогоор, авлигыг хянах механизм 18.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 60.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 13.9 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд тус байгууллагын хувьд авлигын бодит тохиолдлын үнэлгээ хамгийн их оноогоор буурсан нь ийнхүү буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ. Авлигын бодит тохиолдол хамгийн их оноогоор буурч үнэлэгдсэн шалтгааныг тодруулахад судалгаанд хамрагдсан оролцогчдын 50 хувь нь мэдэхгүй гэсэн хариулттай холбоотой байв.

БОУ-г дэд үзүүлэлтүүдээр авч үзвэл, 2024 онд авлигын талаарх төсөөлөл 68.6 оноотой болж, 2023 онтой харьцуулахад 7.8 оноогоор, авлигыг хянах механизм 49.8 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад 6.7 оноогоор, авлигын бодит тохиолдол 90 оноотой болж, өмнөх оноос 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 59.9 оноотой болж, өмнөх оноос 4.5 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. БОУ-нд авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдлын үнэлгээ өндөр байдаг бол, авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үзүүлэлтүүдийн үнэлгээ бага байдаг байна. 2024 оны үнэлгээнээс харахад авлигыг хянах механизм хамгийн бага буюу 49.6 оноогоор үнэлэгдсэн бол, авлигын бодит тохиолдол хамгийн өндөр буюу 90.0 оноотой үнэлэгджээ. Үүнээс харахад төрийн байгууллагуудын авлигын бодит тохиолдол нь бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй бага байдаг нь харагдаж байна. Дэд үзүүлэлтүүдийг байгууллагын төрлөөр авч үзвэл дүүргүүдийн ЗДТГ-ын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр буурсан буюу 13.3 оноогоор буурсан бол, авлигыг хянах механизм яамдын хувьд хамгийн ихээр буурсан буюу 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд хамгийн ихээр буурсан буюу 11.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл яамдуудын хувьд хамгийн ихээр буурсан буюу 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар Монгол улсад авлигын өнөөгийн нөхцөл байдал “Түгээмэл” гэж хариултын эзлэх хувь нийт судалгаанд оролцогчдын 43.5 хувийг эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад “Түгээмэл” гэж үзэж байгаа хариултын эзлэх хувь өндөр хэвээр хадгалагдаж байна. Мөн бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар Монгол улсад авлига хамгийн их тархсан институц “Шүүх” гэж нэгдүгээрт эрэмбэлэгджээ. 2023 онтой харьцуулахад эхний 5 байрт эрэмбэлэгдсэн төрийн байгууллагууд хэвээр хадгалагдсаар байна. Үүнд: Шүүх, газрын алба, эрүүл мэндийн байгууллага, улс төрийн нам, гаалийн байгууллагууд эхний 5 байрт эрэмбэлэгдэж байна.

Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллага дахь авлигыг бууруулахад сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, түгээх ажлыг хийх нь Монгол улс дахь авлигыг бууруулна гэж судалгаанд оролцогчдын 18.1 хувь нь үзжээ. Харин Монгол улс дахь авлигын үндсэн шалтгаан нөхцөл нь ядуурал, амьжиргааны түвшин доогуур байгаа байдал гэж судалгаанд оролцогчдын 15.4 хувь нь үзсэн байна.

“Авлигатай тэмцэх газар”-ын үйл ажиллагааг “Дунд зэрэг” гэж үзэж байгаа бодлогод, оролцогч шинжээчдийн эзлэх хувь судалгаанд оролцогчдын 39.7 хувийг эзэлж байна.

БОУ-нд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн шинжилгээг үнэлж үзэхэд авлигын бодит тохиолдлын үнэлгээ, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үнэлгээ нь хамгийн ихээр нөлөөлж байгаа нь регрессийн шинжилгээний үр дүнгээс харагдсан. Тухайлбал, төрийн байгууллагуудын авлигын бодит тохиолдлын үнэлгээ 10 хувь өсөхөд БОУ 3.5 хувиар өсөхөөр байна. Мөн БОУ-нд асуултуудын үзүүлж байгаа нөлөөг харах зорилгоор хийсэн регрессийн шинжилгээний үр дүнд авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл хамгийн хүчтэй нөлөөлдөг нь батлагдсан. Тиймээс төрийн байгууллагууд авлигын бодит тохиолдлын үнэлгээгээ сайжруулах, төрийн байгууллагуудын удирдлага болон дунд түвшний менежерүүд нь авлигатай тэмцэх, шударга байдлыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлээ сайжруулах нь шударга байдлаа дээшлүүлэхэд хамгийн чухал нөлөөтэй байна.


БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

1.1 Шударга байдлын үнэлгээний аргачлал

1.1.1 Үнэлгээний загвар

Бодлогод оролцогчдын үнэлгээнд авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдол болон авлигыг хянах механизм, удирдлагын хүсэл эрмэлзлийн нийт 16 үзүүлэлт багтана.

Зураг 1. Үнэлгээний загвар



1.1.2 Үнэлгээний утга

Шударга байдлын үнэлгээг **0-100** хүртэлх оноогоор гаргадаг бөгөөд үнэлгээний утга **100-тай** тэнцүү бол **хамгийн шударгыг** илэрхийлнэ. Шударга байдлын үнэлгээ болон түүнийг бүрдүүлэгч үнэлгээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцно.

Бодлогод оролцогчдын үнэлгээ

$$P_i = \frac{A_i + B_i + C_i}{3}$$

P_i - i-р байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ

A_i - авлигын талаарх төсөөллийн оноо

B_i - авлигын хяналтын оноо

C_i - авлигын хяналтын бодит тохиолдлын тоо

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулахдаа дараах 2 аргын аль тохирохыг ашиглана. Үүнд:

- Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсвэл
- Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах

Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулахдаа 1-5 хүртэл хэмжээс бүхий Лайкертын хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэх ба дараах загварыг баримтална. Хэрвээ тухайн хариулт эерэг утгатай бол 100, сөрөг утгатай бол 0 оноог өгнө.

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг ШБҮ-ний 0-100 оноонд шилжүүлэх

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100
Түгээмэл	2	25 эсвэл 75
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25
Огт байхгүй	5	100 эсвэл 0

Үзүүлэлтийн дундаж оноог тооцохдоо тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцно. Дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.


$$\text{Үзүүлэлтийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах: Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

1.2 Судалгааны хамрах хүрээ

“Төрийн байгууллагуудын бодлогод оролцогчид, шинжээчдээс шударга байдлын үнэлгээ”-ний судалгаанд 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, Нийслэл, дүүргийн ЗДТГ-10 нийт 81 байгууллагын 1530 бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөллөөс судалгааны тоон мэдээллийг цуглууллаа. Түүврийн хэмжээг дараах схемээр харуулав.

Схем 1. Түүврийн хамрах хүрээ, түүврийн хэмжээ



Үүнд: Яамны түвшинд бодлого боловсруулахад оролцсон 400 шинжээч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагын түвшинд бодлого боловсруулахад оролцсон 680 шинжээч,


аймаг, нийслэлийн ЗДТГ-ын түвшинд бодлого боловсруулахад оролцсон 450 шинжээч нийт 1530 бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөллийг судалгаанд хамрууллаа. (Түүврийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).

1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2024 оны 07 сарын 01-нээс 2024 оны 09 сарын 08-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 30 хүн ажилласан.

Судалгааны багийн гишүүн нь судалгаа хэрхэн авах талаарх аргазүйн сургалтад хамрагдаж, мэдээлэл цуглуулах ажлыг талбар дээр нь гүйцэтгэн ажилласан болно. Мөн бид судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үйл явцыг тухайн төрийн байгууллагаар одоо цаг үед үйлчлүүлж буй иргэд, ААН болон өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН, тухайн байгууллагын бодлого боловсруулах үйл явцад оролцсон шинжээчидтэй холбогдон мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэлээ. Асуулгын хуудсыг онлайн хэлбэрт шилжүүлэн, тухайн байгууллагын вэбсайт болон тухайн байгууллагын ЭБАТ-аас өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН-ийн холбогдох утасны дугаар, мэйл хаяг зэрэг мэдээллийг авч холбогдох зэрэг аргуудыг ашиглалаа.

Схем 2. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт



БҮЛЭГ 2. БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгаанд нийт 1530 бодлогод оролцогч, шинжээчдийг хамрагдсан.

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчийн төлөөлж буй хүрээ

№	Шинжээчийн төлөөлж буй хүрээ	Оролцогчдын тоо	Эзлэх хувь
1	Төрийн албан хаагч	508	33.3%
2	Төрийн бус байгууллага	311	20.3%
3	Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл	283	18.4%
4	Эрдэмтэн, судлаач	110	7.2%
5	Бодлого боловсруулагч	95	6.2%
6	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч	78	5.1%
7	Аудитор, хяналтын ажилтан	67	4.4%
8	Бусад	78	5.1%
Нийт дүн		1530	100.0%

Шинжээчийн төлөөлж буй хүрээгээр авч үзвэл судалгаанд оролцогчдын 33.3 хувь нь төрийн албан хаагч, 20.3 хувь нь төрийн бус байгууллага, 18.4 хувь нь хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.2 хувь нь эрдэмтэн, судлаач, 6.2 хувь нь бодлого боловсруулагч, 5.1 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.4 хувь нь аудитор, хяналтын ажилтан, 5.1 хувь нь бусад салбарыг тус тус төлөөлж байна.


2.2 Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээний ерөнхий үр дүн

Төрийн байгууллагын бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ (БОУ) нь тухайн байгууллагын авлигын талаарх төсөөллийн 9 үзүүлэлт (тухайн байгууллагын авлигын түгээмэл байдал, албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх явдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автах явдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийгүй ёстой үйлдлийг хийх явдал, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал), авлигын хяналтын 3 үзүүлэлт (дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үр дүнтэй байдал), авлигын бодит тохиолдлын 2 үзүүлэлт (тухайн байгууллагын алба хаагчдад та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс нь нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгсөн явдал, бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгсөн явдал), удирдлагын авлигатай тэмцэх хүслийн 2 үзүүлэлт (удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл, дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл) зэрэг үзүүлэлтүүдийн дунджаар тодорхойлогддог.

БОУ нь 2024 онд 67.1 оноо болж, 2023 онтой харьцуулахад 6.6 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд буурч үнэлэгдэхэд нь авлигын талаарх төсөөлөл 8.0 оноогоор, авлигыг хянах механизм 6.5 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.6 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Үүнээс хамгийн их оноогоор буурсан авлигын талаарх төсөөлөл буурч үнэлэгдэхэд тухайн

байгууллага дахь авлигын түгээмэл байдал (10.7↓), албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (10.4↓), нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (11.0↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (10.2↓) хамгийн их оноогоор буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ (дэлгэрэнгүйг БОУ-ний дэд үзүүлэлтүүдийн үр дүн хэсгээс харна уу).

График 1. БОУ, оноогоор, байгууллагын төрлөөр



Байгууллагын төрлөөр авч үзвэл яамдын БОУ нь 68.6 оноо болж, 2023 онтой харьцуулахад 8.7 оноогоор, агентлагуудын БОУ нь 69.9 оноо болж, 2023 онтой харьцуулахад 5.4 оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ нь 62.2 оноо болж, 2023 онтой харьцуулахад 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. Яамдын БОУ буурч үнэлэгдэхэд яамдын авлигын талаарх төсөөлөл 10.6 оноогоор, авлигыг хянах механизм 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 6.7 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Яамдын БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөллөөр хамгийн их оноогоор буурсан Боловсрол, шинжлэх ухааны яам 51.4 оноогоор, авлигыг хянах механизм Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (34.5↓), авлигын бодит тохиолдол Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам (51.6↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Боловсрол, шинжлэх ухааны яам (37.7↓) оноогоор хамгийн ихээр буурсан байв (дэлгэрэнгүйг яамдын БОУ-ний үр дүн хэсгээс харна уу).

Агентлагуудын БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 6.3 оноогоор, авлигыг хянах механизм 6.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 4.6 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.1 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлсөн бол, аймаг, нийслэлийн БОУ буурч үнэлэгдэхэд авлигын бодит тохиолдол бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь буюу 11.9 оноогоор буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Аймаг, нийслэлийн БОУ-ний бусад үзүүлэлтүүдийн хувьд тухайлбал, авлигын талаарх төсөөлөл 6.5 оноогоор, авлигыг хянах механизм 4.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 3.1 оноогоор тус тус буурсан байна. Агентлагуудын БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөллийн хамгийн их бууралттай агентлаг Үндэсний геологийн алба (35.3↓), авлигыг хянах механизм Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (31.9↓), авлигын бодит тохиолдол Үндэсний геологийн алба (47.3↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Ашигт малтмал, газрын тосны газар (23.4↓) оноогоор буурсан нь хамгийн өндөр бууралттай агентлагууд байлаа (дэлгэрэнгүйг агентлагуудын БОУ-ний үр дүн хэсгээс харна уу). Аймаг, нийслэлийн БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөллийн хамгийн их бууралттай аймаг Баянхонгор

аймгийн ЗДТГ (41.5↓), авлигыг хянах механизм Говь-Алтай аймгийн ЗДТГ (26.4↓), авлигын бодит тохиолдол Говьсүмбэр аймгийн ЗДТГ (60.4↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл Баянхонгор аймгийн ЗДТГ (30.2↓) оноогоор буурсан нь хамгийн өндөр бууралттай аймгууд байлаа(дэлгэрэнгүйг аймаг, нийслэлийн БОУ-ний үр дүн хэсгээс харна уу).

2.2.1 БОУ хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

БОУ-гээр хамгийн өндөр оноо авсан болон хамгийн бага оноо авсан байгууллагуудыг дараах хүснэгтээр харууллаа. 2024 онд “Хууль зүй дотоод хэргийн яам” хамгийн өндөр буюу 88.5 оноотой үнэлэгдэж тэргүүлсэн бол, Говьсүмбэр аймгийн ЗДТГ хамгийн бага буюу 40.3 оноотой үнэлэгдэж сүүлд эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 3. БОУ, хамгийн өндөр болон хамгийн бага оноо авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны оноо	2024 оны оноо	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	19	1	79.7	88.5	8.8
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	12	2	81.4	85.9	4.5
3	Батлан хамгаалах яам	25	3	77.9	84.8	6.9
4	Төв аймгийн ЗДТГ	69	4	65.6	84.3	18.7
5	Оюуны өмчийн газар	39	5	75.2	80.9	5.7
Хамгийн бага үнэлгээтэй:						
77	Үндэсний геологийн алба	37	77	75.6	48.1	-27.5
78	Сүхбаатар аймгийн ЗДТГ	45	78	74.0	48.0	-26.0
79	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59	79	69.1	45.4	-23.7
80	Баянхонгор аймгийн ЗДТГ	48	80	73.5	44.8	-28.7
81	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	51	81	73.0	40.3	-32.7

Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын дундаж БОУ нь улсын дундаж БОУ-нээс 17.8 оноогоор өндөр байгаа бол, 2023 онтой харьцуулахад 8.9 оноогоор өсч үнэлэгджээ. Хамгийн өндөр оноотой 5 байгууллагын хувьд авлигыг хянах механизм хамгийн бага буюу 71.7 оноотой үнэлэгдсэн бол, авлигын бодит тохиолдол хамгийн өндөр буюу 98.9 оноотой үнэлэгдсэн байна. 2023 онтой харьцуулахад БОУ-ний дэд үзүүлэлтүүд дунджаар авлигын талаарх төсөөлөл 9.8 оноогоор, авлигыг хянах механизм 11.5 оноогоор, авлигын бодит тохиолдол 0.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 15.3 оноогоор тус тус өссөн нь өндөр үнэлэгдэхэд нөлөөлсөн бөгөөд үүнээс удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, авлигыг хянах механизм хамгийн ихээр нөлөөлжээ. Тухайлбал, хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн “Хууль зүй, дотоод хэргийн яам” -ын хувьд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 7.3 оноогоор, авлигыг хянах механизм 12.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 15.1 оноогоор өссөн бол, авлигын бодит тохиолдлын өөрчлөлт хэвээр байна. Хамгийн өндөр үнэлгээтэй байгууллагуудын хувьд БОУ өсч үнэлэгдэхэд авлигыг хянах механизм түүн дотроо авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл хамгийн ихээр сайжирсан нь ийнхүү нөлөөлжээ. Авлигын бодит тохиолдлын үнэлгээ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Оюуны өмчийн газрын хувьд харгалзан 2.5 болон 2.8 оноогоор буурч үнэлэгдсэн бол, бусад байгууллагуудын хувьд өсч үнэлэгджээ.

БОУ-ээр Төв аймгийн ЗДТГ хамгийн өндөр өсөлттэй байгаа бөгөөд бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр өсч үнэлэгдсэн буюу албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (21.4↑), ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (35.2↑), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (26.4↑), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (20.1↑), шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах шан харамж шаардах байдал (55.8↑) өсч үнэлэгдсэн нь хүчтэй нөлөөлжээ.

Хүснэгт 4. БОУ, хамгийн өндөр оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

№	Байгууллагын нэр	2024 оны БОУ оноо	Дэд үзүүлэлтийн үнэлгээ				БОУ, өөрчлөлтөөр
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	88.5	86.3	81.2	100.0	86.6	8.8
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	85.9	88.1	78.9	97.5	78.9	4.5
3	Батлан хамгаалах яам	84.8	90.9	69.6	100.0	78.7	6.9
4	Төв аймгийн ЗДТГ	84.3	95.5	62.1	100.0	79.7	18.7
5	Оюуны өмчийн газар	80.9	83.3	66.6	97.2	76.3	5.7
Дундаж		84.9	88.8	71.7	98.9	80.0	8.9

Хамгийн бага оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын БОУ-ний дундаж нь улсын дундаж БОУ-нээс 21.8 оноогоор доогуур үнэлэгджээ. Хамгийн бага оноотой үнэлэгдсэн 5 байгууллагын авлигыг хянах механизм нь бусад дэд үзүүлэлттэй харьцуулахад хамгийн бага буюу 41.3, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 42.5 оноотой үнэлэгдсэн байна. 2023 онтой харьцуулахад 5 байгууллагын дунджаар авлигын талаарх төсөөлөл 32.6 оноогоор, авлигыг хянах механизм 11 оноогоор, авлигын бодит тохиолдол 46.7 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 20.6 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдол хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь БОУ буурахад нөлөөлжээ (Дэлгэрэнгүйг 2.4 хэсгээс харна уу).

Хүснэгт 5. БОУ, хамгийн бага оноо авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

№	Байгууллагын нэр	2024 оны БОУ оноо	Дэд үзүүлэлтийн үнэлгээ				БОУ, өөрчлөлт, оноогоор
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	
77	Үндэсний геологийн алба	48.1	45.8	47.9	52.7	46.0	-27.5
78	Сүхбаатар аймгийн ЗДТГ	48.0	49.8	41.9	56.1	44.2	-26.0
79	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	45.4	44.9	44.5	48.4	43.9	-23.7
80	Баянхонгор аймгийн ЗДТГ	44.8	37.5	38.9	66.1	36.8	-28.7
81	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	40.3	48.9	33.1	37.5	41.7	-32.7
Дундаж		45.3	45.4	41.3	52.2	42.5	-27.7

2.2.2 Яамдын бодлогод оролцогчдын үнэлгээ

Яамдын 2024 оны БОУ нь 68.6 болж 2023 онтой харьцуулахад 8.7 оноогоор буурч үнэлэгдсэн байна. “Хууль зүй, дотоод хэргийн яам”, “Батлан хамгаалах яам”, “Соёлын яам” зэрэг байгууллагуудын БОУ өсч үнэлэгдсэн ч, бусад яамдын БОУ буурсан нь ийнхүү буурч үнэлэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал, “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” -ны БОУ хамгийн бага буурсан байгаа бол, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-ны БОУ хамгийн ихээр буурсан байна.

Хүснэгт 6. Яамдын БОУ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	6	1	79.7	88.5	8.8
2	Батлан хамгаалах яам	9	2	77.9	84.8	6.9
3	Соёлын яам	14	3	71.6	80.0	8.4
4	Гадаад харилцааны яам	2	4	82.9	78.5	-4.4
5	Барилга хот байгуулалтын яам	8	5	78.4	76.3	-2.1
6	Сангийн яам	12	6	75.1	71.2	-3.9
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	11	7	75.7	71.1	-4.6
8	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	1	8	83.2	70.8	-12.4
9	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	13	9	71.8	70.5	-1.3
10	Эрүүл мэндийн яам	4	10	80.7	67.8	-12.9
11	Зам, тээврийн хөгжлийн яам	15	11	71.3	65.0	-6.3
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3	12	82.4	61.5	-20.9
13	Эрчим хүчний яам	7	13	79.2	59.1	-20.1
14	Эдийн засаг хөгжлийн яам	5	14	79.8	57.3	-22.5
15	Боловсрол, шинжлэх ухааны яам	10	15	77.6	49.2	-28.4
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	16	16	69.1	45.4	-23.7
	Яамдын БОУ			77.3	68.6	-8.7

Яамдын БОУ буурч үнэлэгдэхэд дараах үзүүлэлтүүдийн бууралт нөлөөлсөн байна. Тухайлбал, яамдын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 10.6 оноогоор, авлигыг хянах механизм 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 6.7 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Бодлогод оролцогч, шинжээчид яамдын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм илүү их буурсан гэж үнэлсэн нь хамгийн их нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал, тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? Гэсэн үзүүлэлт (8.6↓), яамдын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (12.8↓), ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (8.5↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (12.4↓), нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (17.2↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (16.1↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (12.6↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (11.9↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (13.2↓), авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (12.2↓), шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (5.8↓), сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (5.9↓), сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (8.4↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл (6.2↓), дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл (5.8↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Харин яамдын албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт 4.6 оноогоор өсч үнэлэгджээ. “Хууль зүй, дотоод хэргийн яам”-ны хувьд авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 2023 онтой харьцуулахад 12.9-15.1 оноогоор өссөн нь БОУ өсөхөд нөлөөлсөн бол, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-ны хувьд авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл харгалзан 51.6, 26.1 оноогоор буурсан нь тус байгууллагын БОУ хамгийн ихээр буурахад нөлөөлжээ.

2.2.3 Агентлагуудын бодлогод оролцогчдын үнэлгээ

Агентлагуудын БОУ 2024 онд 69.9 болж, өмнөх оноос 5.4 оноогоор буурч үнэлэгдсэн нь дараах хүснэгтээс харагдаж байна. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар”, “Оюуны өмчийн газар”, “Жижиг дунд үйлдвэрийн газар”, “Шүүх шинжилгээний ерөнхий газар”, “Усны газар”, “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар”, “Мал эмнэлгийн еөрнхий газар”, “Биеийн тамир, спортын улсын хороо”, “Нийгмийн даатгалын ерөнхий газар”, “Иргэний нисэхийн ерөнхий газар” зэрэг 10 байгууллагуудын БОУ 0.6-12.3 оноогоор өсч үнэлэгдсэн бол, бусад агентлагуудын БОУ 0.5-27.5 оноогоор буурч үнэлэгдсэн байна.

Агентлагуудын БОУ буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, 2023 онтой харьцуулахад агентлагуудын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүд бүгд буурч үнэлэгдсэн ч, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар агентлагуудын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм харгалзан 6.2, 6.4 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна. Эдгээр үзүүлэлтүүд буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? Гэсэн үзүүлэлт (9.7↓), агентлагуудын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (8.2↓), ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (2.6↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (6.6↓), нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (11.1↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (8.5↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (7.8↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (7.8↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (7.8↓), авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (5.9↓), шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (5.0↓), сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (4.4↓), сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (4.7↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл (3.3↓), дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл (5.0↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Агентлагуудын албан хаагчдын бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах үзүүлэлт 5.4 оноогоор өсч үнэлэгджээ.

Хүснэгт 7. Агентлагуудын БОУ, 2023, 2024 оны харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	9	1	81.5	85.9	4.4
2	Оюуны өмчийн газар	23	2	75.2	80.9	5.7
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	14	3	79.5	80.1	0.6
4	Шүүх шинжилгээний ерөнхий газар	25	4	70.3	78.2	7.9
5	Стандарт, хэмжил зүйн газар	2	5	85.4	76.9	-8.5
6	Соёл урлагийн газар	16	6	77.3	76.8	-0.5
7	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	11	7	80.3	76.0	-4.3

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
8	Усны газар	26	8	68.0	75.4	7.4
9	Гадаадын иргэн харьяатын газар	1	9	86.9	75.2	-11.7
10	Улсын бүртгэлийн ерөнхий газар	21	10	75.7	74.7	-1.0
11	Онцгой байдлын ерөнхий газар	17	11	76.2	74.0	-2.2
12	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	10	12	80.7	73.5	-7.2
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	31	13	61.1	73.4	12.3
14	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	3	14	85.2	72.5	-12.7
15	Мал эмнэлгийн ерөнхий газар	27	15	67.6	72.4	4.8
16	Цагдаагийн ерөнхий газар	24	16	75.0	72.2	-2.8
17	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	5	17	83.3	71.4	-11.9
18	Биеийн тамир, спортын улсын хороо	28	18	64.7	71.4	6.7
19	Ойн газар	15	19	78.8	71.3	-7.5
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	7	20	82.5	70.3	-12.2
21	Татварын ерөнхий газар	18	21	75.8	70.0	-5.8
22	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	8	22	81.5	69.5	-12.0
23	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	20	23	75.7	69.2	-6.5
24	Архивын ерөнхий газар	13	24	80.1	68.6	-11.5
25	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	-	25	-	67.0	-
26	Нийгмийн даатгалын ерөнхий газар	33	26	56.5	66.5	10.0
27	Боловсролын ерөнхий газар	4	27	85.1	65.4	-19.7
28	Төрийн худалдан авах ажиллагааны газар	6	28	83.1	63.9	-19.2
29	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	12	29	80.1	61.6	-18.5
30	Цаг уур, орчны шинжилгээний газар	29	30	62.2	61.3	-0.9
31	Иргэний нисэхийн ерөнхий газар	32	31	57.7	59.0	1.3
32	Гаалийн ерөнхий газар	30	32	61.9	55.6	-6.3
33	Ашигт малтмал, газрын тосны газар	19	33	75.8	49.1	-26.7
34	Үндэсний геологийн алба	22	34	75.6	48.1	-27.5
	Агентлагуудын БОУ			75.3	69.9	-5.4

Агентлагуудаас “Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар”-ын хувьд 2024 онд БОУ хамгийн ихээр буюу 12.3 оноогоор нэмэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсантай холбоотой гэж бодлогод оролцогч, шинжээчид үзсэн байна. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 27.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 21.4 оноогоор тус тус нэмэгдэж үнэлэгджээ.

Харин “Үндэсний геологийн алба”-ын хувьд 2024 онд БОУ хамгийн ихээр буурч буюу 27.5 оноогоор буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 35.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 47.3 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 20.9 оноогоор, авлигыг хянах механизм 6.4 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдлын шударга байдал хамгийн ихээр буурсан гэж үнэлсэн байна. Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 63.8 оноогоор, тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 44.7 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 39.7 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 50.1 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 44.0

оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 59.3 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 38.1 оноогоор, албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 25.0 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 47.0 оноогоор өсч үнэлэгдсэн нь хамгийн сайн үзүүлэлт байв. Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 8.3 оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 27.1 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь авлигыг хянах механизм буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 53.4 оноогоор өсч үнэлэгдсэн нь сайн үзүүлэлт болж байна. Авлигын бодит тохиолдол болох сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал 41.2 оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал 53.3 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь авлигын бодит тохиолдол буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл 26.0 оноогоор, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл 15.8 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үнэлгээ буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

2.2.4 Аймаг, нийслэлийн бодлогод оролцогчдын үнэлгээ

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний хувьд 2024 онд 62.2 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад 6.5 оноогоор буурч үнэлэгджээ. Төв аймгийн ЗДТГ-ын БОУ хамгийн ихээр буюу 18.7 оноогоор өссөн бол, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 32.7 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн БОУ буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, авлигын талаарх төсөөлөл 6.4 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 11.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 3.3 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчид аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын бодит тохиолдол хамгийн их нэмэгдсэн гэж үзсэн байна. Тухайлбал, тухайн байгууллагад авлига хэр түгээмэл вэ? Гэсэн үзүүлэлт (8.2↓), агентлагуудын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (10.9↓), ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал (3.1↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (6.7↓), нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал (13.4↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (10.4↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (8.3↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (9.1↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог явдал (8.2↓), авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (4.0↓), шударга ёсыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал (0.8↓), сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь

холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал (12.5↓), сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал (11.3↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл (5.9↓), дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл (0.8↓) оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 8. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
1	Төв аймгийн ЗДТГ	17	1	59.9	84.3	18.7
2	Дорноговь аймгийн ЗДТГ	8	2	73.3	79.9	6.7
3	Нийслэлийн ЗДТГ	5	3	73.5	75.1	1.6
4	Өвөрхангай аймгийн ЗДТГ	1	4	76.4	72.5	-3.8
5	Булган аймгийн ЗДТГ	13	5	67.4	70.4	3.0
6	Архангай аймгийн ЗДТГ	10	6	72.1	68.6	-3.5
7	Баян-Өлгийн айгийн ЗДТГ	22	7	56.8	67.3	10.5
8	Хөвсгөл аймгийн ЗДТГ	14	8	66.7	66.8	0.1
9	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	16	9	66.0	65.4	-0.6
10	Орхон аймгийн ЗДТГ	2	10	74.2	65.1	-9.1
11	Өмнөговь аймгийн ЗДТГ	15	11	66.3	64.1	-2.2
12	Увс аймгийн ЗДТГ	20	12	59.9	62.8	2.9
13	Дундговь аймгийн ЗДТГ	11	13	69.9	61.7	-8.2
14	Завхан аймгийн ЗДТГ	18	14	64.7	57.4	-7.3
15	Дархан-Уул аймгийн ЗДТГ	12	15	68.4	56.4	-12.0
16	Хэнтий аймгийн ЗДТГ	19	16	62.5	56.2	-6.3
17	Ховд аймгийн ЗДТГ	21	17	59.0	54.4	-4.6
18	Говь-Алтай аймгийн ЗДТГ	3	18	74.1	54.2	-19.9
19	Дорнод аймгийн ЗДТГ	7	19	73.3	52.2	-21.0
20	Сүхбаатар аймгийн ЗДТГ	4	20	74.0	48.0	-26.0
21	Баянхонгор аймгийн ЗДТГ	6	21	73.5	44.8	-28.7
22	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	9	22	73.0	40.3	-32.7
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ			68.7	62.2	-6.5

Төв аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ нь 2024 онд хамгийн ихээр өссөн буюу 18.7 оноогоор нэмэгдэж үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тухайлбал, Төв аймгийн ЗДТГ-ын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 26.4 оноогоор, авлигыг хянах механизм 17.8 оноогоор, авлигын бодит тохиолдол 6.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 24.5 оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд Төв аймгийн ЗДТГ-ын авлигын талаар төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсан гэж үзжээ.

Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ нь 2024 онд хамгийн ихээр буурсан буюу 32.7 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд тус аймгийн хувьд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 38.3 оноогоор, авлигыг хянах механизм 18.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 60.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 13.9 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус аймгийн хувьд авлигын бодит тохиолдол хамгийн их нэмэгдсэн байгаа нь харагдаж байна. Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 37.1 оноогоор, тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 53.4 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 40.8 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 45.6 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 50.8 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 50.8 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 32.8 оноогоор, албан

мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 30.6 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Харин бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 13.9 оноогоор өсч үнэлэгдсэн нь хамгийн сайн үзүүлэлт байв. Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 18.8 оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 15.5 оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 20.8 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь авлигыг хянах механизм буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ. Харин сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал 50.0 оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал 70.8 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь авлигын бодит тохиолдол буурч үнэлэгдэхэд нөлөөлсөн бол, Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл 8.0 оноогоор, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл 19.8 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үнэлгээ буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

2.2.5 Дүүргүүдийн бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн

Дүүргүүдийн БОУ нь 2024 онд 65.6 оноо болж, 2023 онтой харьцуулахад 8.1 оноогоор буурч үнэлэгдсэн байна. 2024 онд Хан-Уул ддүргийн ЗДТГ болон Багануур дүүргийн ЗДТГ-ын БОУ өссөн бол, бусад дүүргүүдийн үнэлгээ буурсан нь дараах хүснэгтээс харагдаж байна. Хан-Уул дүүргийн ЗДТГ 2024 онд хамгийн ихээр өссөн буюу 2023 онтой харьцуулахад 11 оноогоор өссөн бол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буурсан буюу 2023 онтой харьцуулахад 26 оноогоор буурчээ.

Дүүргүүдийн БОУ буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, 2023 онтой харьцуулахад дүүргүүдийн авлигын талаарх төсөөлөл 13.3 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 8.8 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 5.9 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар дүүргүүдийн авлигын талаарх төсөөллийн шударга байдал хамгийн их буурсан нь харагдаж байна.

Хүснэгт 9. Дүүргүүдийн БОУ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	9	1	67.2	78.2	11.0
2	Баянзүрх дүүргийн ЗДТГ	2	2	77.0	73.9	-3.1
3	Багануур дүүргийн ЗДТГ	8	3	68.1	71.5	3.4
4	Налайх дүүргийн ЗДТГ	9	4	75.5	68.6	-6.9
5	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	1	5	78.0	67.6	-10.4
6	Багахангай дүүргийн ЗДТГ	6	6	73.9	66.3	-7.6
7	Баянгол дүүргийн ЗДТГ	5	7	75.2	62.0	-13.2
8	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	7	8	72.0	52.4	-19.6
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	3	9	75.8	49.8	-26.0
	Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ			73.6	65.6	-8.1

2024 онд Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын БОУ бусад дүүргүүдтэй харьцуулахад хамгийн их оноогоор нэмэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 29.7

оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 15.5 оноогоор, авлигын бодит тохиолдол 2.1 оноогоор нэмэгдсэн нь нөлөөлсөн бол, тус дүүргийн хувьд авлигыг хянах механизм 2023 онтой харьцуулахад 3.5 оноогоор буурч үнэлэгджээ.


Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын БОУ нь хамгийн их оноогоор буурахад авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 18.6 оноогоор, авлигыг хянах механизм 22 оноогоор, авлигын бодит тохиолдол 41 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх механизм 22.3 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус дүүргийн хувьд авлигын бодит тохиолдол бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн ихээр буурахад нөлөөлсөн гэж үзжээ.

2.3 Бодлогод оролцогчдын үнэлгээний дэд үзүүлэлтийн үр дүн

Энэ дэд бүлэгт БОУ-ний дэд үзүүлэлтүүд болох авлигын талаарх төсөөллийн индекс, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн индексүүдийн талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны үнэлгээгээр 2024 авлигын талаарх төсөөлөл 68.6 оноотой болж, 2023 онтой харьцуулахад 7.8 оноогоор, авлигыг хянах механизм 49.8 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад 6.7 оноогоор, авлигын бодит тохиолдол 90 оноотой болж, өмнөх оноос 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 59.9 оноотой болж, өмнөх оноос 4.5 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

БОУ-нд авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үзүүлэлтүүд нь бусад 2 үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага үнэлэгддэг нь дараах графикаас харагдаж байна. Тухайлбал, авлигыг хянах механизм нь авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн дунджаас 18.8 оноогоор, авлигын бодит тохиолдлоос 40.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүслээс 10.1 оноогоор тус тус доогуур байгаа бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь авлигын талаарх төсөөллөөс 8.7 оноогоор, авлигын бодит тохиолдлоос 30.1 оноогоор тус тус доогуур үнэлэгдсэн байна. Харин авлигыг хянах механизмаас 10.1 оноогоор дээгүүр үнэлэгджээ.

График 2. БОУ, дэд үзүүлэлтээр, оноор




Авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд 2016 оноос хойш тасралтгүй өсч байсан ч, 2024 онд буурч үнэлэгдсэн бол, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд жил бүр өсч буурсан байдлаар үнэлэгдсэн байна. Харин авлигын бодит тохиолдлын үзүүлэлтийн хувьд бусад үзүүлэлттэй харьцуулахад шударга байдал хамгийн өндөр байдаг үзүүлэлт бөгөөд 2016 оноос хойш тасралтгүй өсч байсан ч, 2024 онд буурч үнэлэгджээ.

Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд 2021 оноос хойш өсч, буурч үнэлэгдсэн байна.

БОУ-ний дэд үзүүлэлтүүдийг байгууллагын төрлөөр авч үзвэл тухайлбал, агентлагуудын авлигын талаарх төсөөлөл үзүүлэлт нь бусад байгууллагуудтай харьцуулахад 2024 онд өндөр буюу дунджаар 72.1 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ бусад байгууллагуудтай харьцуулахад хамгийн бага буюу 64.1 оноотой үнэлэгдсэн байна. Яамдын авлигын талаарх төсөөллийн дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үнэлгээнээс 1.2 оноогоор, агентлагуудын авлигын талаарх төсөөллийн дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үнэлгээнээс 3.5 оноогоор тус тус дээгүүр үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь 2024 оны дунджаас 4.5 оноогоор тус тус доогуур үнэлэгджээ.

Авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд агентлагуудын БОУ нь бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр буюу дунджаар 53.1 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ нь бага буюу дунджаар 44.8 оноотой үнэлэгджээ. Агентлагуудын авлигыг хянах механизм 2024 оны дундаж үзүүлэлтээс 3.3 оноогоор дээгүүр байгаа бол бусад байгууллагуудын үнэлгээ доогуур байгаа нь графикаас харагдаж байна.

График 3. БОУ-ний дэд үзүүлэлт, байгууллагын төрлөөр, 2024 он



Авлигын бодит тохиолдол үзүүлэлтийн хувьд агентлагуудын дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үзүүлэлтээс 3.2 оноогоор өндөр байгаа бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ нь 6.1 оноогоор доогуур үнэлэгдсэн байна.

Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд яамдын дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үзүүлэлтээс 2.8 оноогоор өндөр байгаа бол, аймаг нийслэлийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ нь 4 оноогоор доогуур үнэлэгджээ. Яамдын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь бусад байгууллагуудтай харьцуулахад 2024 онд өндөр байсан байна.

Яамдын БОУ-ний дэд үзүүлэлтийн 2024 оны үнэлгээг 2023 онтой харьцуулж дараах хүснэгтээр харууллаа. Яамдын хувьд авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд 2023 онтой харьцуулахад 10.6 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлт 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа яамдыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Барилга, хот байгуулалтын яам”-ны үзүүлэлт 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр

өссөн буюу 16.3 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Хууль зүй, дотоод хэргийн яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр өссөн буюу 12.9 оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд “Батлан хамгаалах яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр өссөн буюу 1.7 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд “Хууль зүй, дотоод хэргийн яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр өссөн буюу 15.1 оноогоор тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10. Яамдын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	0.6	2.5	-12.0	3.6
2	Барилга хот байгуулалтын яам	16.3	-28.3	0.0	3.5
3	Батлан хамгаалах яам	8.7	6.7	1.7	10.5
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	-51.4	-21.1	-3.5	-37.7
5	Гадаад харилцааны яам	-8.7	-11.2	0.0	2.3
6	Зам, тээвэр хөгжлийн яам	-15.6	-14.4	0.0	4.5
7	Сангийн яам	-5.7	-6.4	-5.0	1.7
8	Соёлын яам	15.2	7.3	0.0	11.0
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	-16.0	-1.0	-51.6	-26.1
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	-16.9	-1.2	0.0	-0.3
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	7.3	12.9	0.0	15.1
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	-19.4	-34.5	-4.9	-24.8
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-8.6	-25.2	0.0	-15.8
14	Эдийн засаг хөгжлийн яам	-33.3	-16.2	-21.8	-18.4
15	Эрүүл мэндийн яам	-16.4	-19.7	0.0	-15.6
16	Эрчим хүчний яам	-25.8	-16.8	-16.7	-21.4
	Дундаж өөрчлөлт, оноогоор	-10.6	-10.4	-7.1	-6.7

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа яамдыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Боловсрол шинжлэх ухааны яам”-ны үзүүлэлт 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр буурсан буюу 51.4 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”-ны хамгийн ихээр буурсан буюу 34.5 оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд “Уул уурхай, хөнгөн үйлдвэрийн яам”-ны хувьд хамгийн ихээр буурсан буюу 51.6 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд “Боловсрол, шинжлэх ухааны яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр буурсан буюу 37.7 оноогоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хүснэгтээр харууллаа. Авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн хувьд 2024 онд 2023 онтой харьцуулахад агентлагуудын хувьд 6.3 оноогоор, авлигыг хянах механизм 6.6 оноогоор, авлигын бодит тохиолдол 4.6 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.2 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа агентлагуудыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар”-ын үзүүлэлт 27.4 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Усны газар”-ын үзүүлэлт 14.6 оноогоор, авлигын бодит тохиолдол “Улсын бүртгэлийн ерөнхий газар”-ын үзүүлэлт 13.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Шүүх шинжилгээний ерөнхий газар”-ын үзүүлэлт 22.5 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад өсч үнэлэгджээ.

Хүснэгт 11. Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Архивын ерөнхий газар	-16.5	-16.1	-3.3	-9.8
2	Ашигт малтмал, газрын тосны газар	-27.8	-11.2	-44.3	-23.4
3	Биеийн тамир, спортын улсын хороо	12.6	7.1	-2.9	10.1
4	Боловсролын ерөнхий газар	-29.3	-30.7	0.0	-19.1
5	Гаалийн ерөнхий газар	-4.6	-6.3	-13.2	-1.0
6	Гадаадын иргэн харьяатын газар	-13.4	-18.1	0.0	-15.4
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	-19.8	-31.9	0.0	-22.2
8	Жижиг, дунд үйлдвэрийн газар	2.9	-10.8	0.0	10.5
9	Иргэний нисэхийн ерөнхий газар	3.9	6.0	-2.0	-2.7
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	8.7	-4.8	0.0	15.2
11	Нийгмийн даатгалын ерөнхий газар	24.5	7.8	9.2	-1.5
12	Ойн газар	1.9	-7.3	-10.1	-14.7
13	Онцгой байдлын ерөнхий газар	-6.3	-10.1	6.1	1.3
14	Оюуны өмчийн газар	2.7	6.2	-2.8	16.3
15	Соёл урлагийн газар	4.8	-6.1	-3.1	2.5
16	Стандарт, хэмжил зүйн газар	-14.1	-13.1	0.0	-6.8
17	Татварын ерөнхий газар	-7.6	-5.6	2.6	-12.6
18	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	-8.0	-20.7	-0.5	0.4
19	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-20.9	-18.4	-19.4	-17.9
20	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-12.8	0.4	-0.6	-3.9
21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	-1.4	-2.4	13.9	-13.7
22	Усны газар	16.8	14.6	2.5	-4.3
23	Үндэсний геологийн алба	-35.3	-6.4	-47.3	-20.9
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-3.8	-16.5	5.1	-10.6
25	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	-14.2	-12.6	0.0	-20.8
26	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	-	-	-	-
27	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	27.4	0.4	0.0	21.4
28	Цаг уур, орчны шинжилгээний газар	-12.0	10.1	-17.4	15.9
29	Цагдаагийн ерөнхий газар	-3.6	-6.0	7.1	-8.7
30	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	-14.8	-12.9	-12.1	-8.8
31	Шүүх шинжилгээний ерөнхий газар	1.9	10.0	-2.9	22.5
32	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	-3.7	13.9	-2.5	10.2
33	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-23.2	-11.1	0.0	-13.8
34	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	-24.2	-3.6	-12.9	-10.2
	Дундаж өөрчлөлт, оноогоор	-6.3	-6.6	-4.6	-4.2

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа агентлагуудыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Үндэсний геологийн алба”-ны үзүүлэлт 35.3 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-ын үзүүлэлт 31.9 оноогоор, авлигын бодит тохиолдол “Үндэсний геологийн алба”-ны үзүүлэлт 47.3 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Ашигт малтмал, газрын тосны газар”-ын үзүүлэлт 23.4 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад буурч үнэлэгджээ.

Аймаг, нийслэлийн БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг 2023 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл үзүүлэлт 6.4 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 11.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 3.3 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй

байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Төв аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 26.4 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Төв аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 17.8 оноогоор, авлигын бодит тохиолдол “Увс аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 9.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Төв аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 24.5 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад өсч үнэлэгджээ.

Хүснэгт 12. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Архангай аймгийн ЗДТГ	-21.5	8.3	5.4	-6.2
2	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	26.0	1.3	9.2	5.4
3	Баянхонгор аймгийн ЗДТГ	-41.5	-12.8	-30.1	-30.2
4	Булган аймгийн ЗДТГ	0.8	10.2	-14.3	15.1
5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	-23.7	-26.4	-18.2	-11.4
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	-38.3	-18.4	-60.4	-13.9
7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	-17.1	-5.2	-17.3	-8.5
8	Дорноговь аймгийн ЗДТГ	15.5	3.9	-3.8	11.1
9	Дорнод аймгийн ЗДТГ	-25.3	-25.8	-11.4	-21.6
10	Дундговь аймгийн ЗДТГ	-13.5	4.0	-10.5	-13.0
11	Завхан аймгийн ЗДТГ	-4.7	1.1	-33.6	8.0
12	Орхон аймгийн ЗДТГ	-4.5	-11.2	-11.8	-9.0
13	Өвөрхангай аймгийн ЗДТГ	-6.0	-6.0	0.0	-3.3
14	Өмнөговь аймгийн ЗДТГ	3.7	-9.3	1.8	-5.0
15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	-32.0	-16.6	-43.9	-11.6
16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	1.6	6.1	-8.8	-1.5
17	Төв аймгийн ЗДТГ	26.4	17.8	6.1	24.5
18	Увс аймгийн ЗДТГ	8.0	-4.4	9.4	-1.4
19	Ховд аймгийн ЗДТГ	-2.5	3.4	-18.5	-1.1
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	-4.3	-14.6	5.3	13.9
21	Хэнтий аймгийн ЗДТГ	-1.9	1.6	-18.1	-6.8
22	Нийслэлийн ЗДТГ	13.6	-2.6	2.2	-6.6
	Дундаж өөрчлөлт, оноогоор	-6.4	-4.3	-11.9	-3.3

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Баянхонгор аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 41.5 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Гвь-Алтай аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 26.4 оноогоор, авлигын бодит тохиолдол “Говьсүмбэр аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 60.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Баянхонгор аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 30.2 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад буурч үнэлэгджээ.

Дүүргүүдийн БОУ-ний дэд үзүүлэлтийг 2023 онтой харьцуулсан өөрчлөлтөөс харахад авлигын талаарх төсөөлөл 13.3 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 8.8 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 5.9 оноогоор тус тус буурсан байна. Дэд үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй дүүргийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл “Хан-Уул дүүргийн ЗДТГ”-ын хувьд 29.7 оноогоор өссөн бол, авлигыг хянах механизм “Багахангай дүүргийн ЗДТГ”-ын хувьд 20.1 оноогоор өсчээ. Харин авлигын бодит тохиолдол “Баянзүрх дүүргийн ЗДТГ”-ын хувьд 5.9 оноогоор өссөн бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Хан-Уул дүүргийн ЗДТГ”-ын хувьд 15.5 оноогоор өсч үнэлэгджээ.

Хүснэгт 13. Дүүргүүдийн БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Багануур дүүргийн ЗДТГ	4.4	3.9	0.0	5.3
2	Багахангай дүүргийн ЗДТГ	-49.9	20.1	2.6	-3.2
3	Баянгол дүүргийн ЗДТГ	-22.7	-6.0	-22.0	-2.1
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	-7.5	-11.3	5.9	0.4
5	Налайх дүүргийн ЗДТГ	-8.3	-8.8	2.5	-13.3
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	-30.4	-7.5	-23.0	-17.8
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	-16.1	-3.4	-6.7	-15.3
8	Хан-Уул дүүргийн ЗДТГ	29.7	-3.5	2.1	15.5
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	-18.6	-22.0	-41.0	-22.3
	Дундаж өөрчлөлт, оноогоор	-13.3	-4.3	-8.8	-5.9

Дэд үзүүлэлтийн хувьд 2023 онтой харьцуулахад хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа дүүргийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Багахангай дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 49.9 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 22 оноогоор, авлигын бодит тохиолдол үзүүлэлтийн хувьд “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 41 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 22.3 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг 2023 онтой харьцуулсан үзүүлэлтээс харахад БОУ-ээр дүүргүүдийн ЗДТГ-ын хувьд авлигын талаар төсөөллийн шударга байдал хамгийн их буурсан бол, авлигыг хянах механизм яамдын хувьд хамгийн их буурсан байна.

Хүснэгт 14. БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, байгууллагын төрлөөр, 2023 онтой харьцуулсан байдал (нэгтгэсэн)

Дундаж өөрчлөлт	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
Яам	-10.6	-10.4	-7.1	-6.7
Агентлаг	-6.3	-6.6	-4.6	-4.2
Аймаг, нийслэлийн ЗДТГ	-6.4	-4.3	-11.9	-3.3
Дүүргүүдийн ЗДТГ	-13.3	-4.3	-8.8	-5.9

Харин авлигын бодит тохиолдол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд хамгийн их байгаа бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл яамдуудын хувьд хамгийн их буурчээ.

2.4 БОУ гүйцэтгэл бага байгууллагууд

Энэ хэсэгт 2024 онд хамгийн бага БОУ авсан байгууллагууд болон тус онд өмнөх оноос хамгийн их үнэлгээний бууралттай байгууллагуудын үнэлгээний үзүүлэлтүүдийг тус бүрчлэн задлан шинжлэв.

2.4.1 Хамгийн бага үнэлгээ бүхий байгууллагууд

БОУ нь хамгийн бага 5 байгууллагын хувьд үнэлгээний бууралтанд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн талаар байгууллага тус бүрээр авч үзье (Бусад байгууллагын дэлгэрэнгүйг хавсралт -аас харна уу).

1. Үндэсний геологийн алба

Үндэсний геологийн алба нь 2024 онд БОУ-ээр 40 байр ухарч, 77 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. БОУ нь 2023 онтой харьцуулахад 27.5 оноогоор буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 35.3 оноогоор, авлигыг хянах механизм 6.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 47.3 оноогоор, удирдлагын

авлигатай тэмцэх хүсэл 20.9 оноогоор тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Тухайлбал, тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл нь буурч үнэлэгдэхэд:

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 63.8 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцсон 20 бодлогод оролцогч, шинжээчдийн 13 нь түгээмэл, ихээхэн түгээмэл гэж хариулсан нь хамгийн ихээр нөлөөлсөн байна.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 2023 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн буюу “Огт байхгүй” гэсэн хариулт сонгогдоогүй нь үүнд нөлөөлсөн байна.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 39.7 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 50.1 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 44.0 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 59.3 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 38.1 оноогоор тус тус буурахад судалгаанд оролцогчид ихээхэн түгээмэл, түгээмэл, дунд зэрэг гэсэн хариултуудыг сонгосон нь маш ихээр нөлөөлжээ.
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 25.0 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь дунд зэрэг гэсэн хариултыг өгсөн нь ингэж нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 47.0 оноогоор өсч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 30 хувь нь маш ил тод, ил тод, 50 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 8.3 оноогоор
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 27.1 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Заримдаа” гэсэн хариултыг өгсөн нь нөлөөлсөн байна. Харин тус байгууллагын хувьд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 53.4 оноогоор өсч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын хариултын тархалт бүх хариулт дээр жигд тархсан байгаа нь нөлөөлсөн байв.

Хүснэгт 15. Үндэсний геологийн албын БОУ-ний дэд үзүүлэлт, түүний өөрчлөлт

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
		БОУ	75.6	48.1
	Авлигын талаарх төсөөлөл	81.1	-35.3	-35.3
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	93.8	30.0	-63.8
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	92.1	47.4	-44.7
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	81.8	42.1	-39.7
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	92.2	42.1	-50.1
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	91.2	47.2	-44.0
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	92.1	32.8	-59.3
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	86.8	48.7	-38.1

- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 29.5 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 30 хувь нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн нь хүчтэй нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 20.3 оноогоор өсч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 60 хувь нь дунд зэрэг, 30 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 16. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын БОУ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
	БОУ	74.0	48.0	-26.0
	Авлигын талаарх төсөөлөл	81.8	49.8	-32.0
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	87.5	41.7	-45.8
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	90.0	46.7	-43.3
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	88.3	48.2	-40.1
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	89.2	56.3	-32.9
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	87.9	54.5	-33.4
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	90.0	44.6	-45.4
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	90.0	52.3	-37.7
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	22.2	42.5	20.3
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	90.8	61.4	-29.5
	Авлигыг хянах механизмын үзүүлэлт	58.5	41.9	-16.6
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	62.9	36.5	-26.4
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	55.2	39.3	-15.9
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	57.5	50.0	-7.5
	Авлигын бодит тохиолдол	100.0	56.1	-43.9
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	100.0	58.3	-41.7
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	100.0	53.8	-46.2
	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	55.8	44.2	-11.6
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	55.8	46.2	-9.6
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	55.8	42.3	-13.5

Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 26.4 оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 15.9 оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 7.5 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Нийлэхгүй”, “Дунд зэрэг” гэсэн хариултуудыг өгсөн нь нөлөөлжээ. Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчдийн 30 хувь нь гэр бүлийн гишүүд болон, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн талаар сонсож байсан бол, 40

хувь нь бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан талаар сонссон гэж хариулсан ийнхүү буурахад нөлөөлжээ. Удирдлагын авлигатай тэмцэл, хүсэл эрмэлзлийг тус байгууллагын хувьд судалгаанд оролцогчдын 50 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлжээ.

3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд 2024 онд БОУ нь 45.4 оноотой болж, 2023 оноос 23.7 оноогоор буурч, 79-р байрт эрэмбэлэгдсэн байна. Тус байгууллагын БОУ буурч үнэлэгдэхэд авлигын бодит тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн жил судалгаанд оролцогчид 100 хувь энэ талаар сонсоогүй байсан бол, энэ жил судалгаанд оролцогчдын 50 хувь нь гэр бүлийн гишүүд болон, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн талаар сонсож байсан бол, мөн бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан талаар сонссон гэж хариулсан нь ийнхүү нөлөөлсөн байна.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 32.9 оноогоор,
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 23.8 оноогоор,
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 18.6 оноогоор,
- Бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 16.0 оноогоор,
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 25.2 оноогоор,
- Хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 44.2 оноогоор,
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 2.1 оноогоор,
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 1.8 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлсөн байна. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 20.7 оноогоор өсч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 60 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлжээ.
- Тус байгууллагын удирдлагын болон дун түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл нь мөн л дунд зэрэг гэж судалгаанд оролцогчдын 50-иас дээш хувь нь үзжээ.

Хүснэгт 17. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны БОУ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
	БОУ	69.1	45.4	-23.7
	Авлигын талаарх төсөөлөл	60.9	44.9	-16.0
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	62.1	29.2	-32.9
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	68.1	44.3	-23.8
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	59.5	40.9	-18.6
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	56.7	40.6	-16.0
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	69.0	43.8	-25.2

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	84.2	40.0	-44.2
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	48.3	46.3	-2.1
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	33.3	54.0	20.7
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	67.3	65.5	-1.8
Авлигыг хянах механизмын үзүүлэлт		45.4	44.5	-1.0
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	34.5	45.8	11.4
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	31.3	48.0	16.8
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	70.5	39.6	-31.0
Авлигын бодит тохиолдол		100.0	48.4	-51.6
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	100.0	52.4	-47.6
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	100.0	44.4	-55.6
Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл		70.1	43.9	-26.2
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл	68.8	42.0	-26.7
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл	71.4	45.8	-25.6

4. Баянхонгор аймгийн ЗДТГ: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хувьд 2024 онд БОУ нь 44.8 оноотой болж, 2023 оноос 28.7 оноогоор буурч 80 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэхэд судалгаанд оролцогчдын 80 хувь нь түгээмэл гэж хариулсан нь 59.4 оноогоор буурах шалтгаан болжээ.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 37.0 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 38.6 оноогоор тус тус буурахад судалгаанд оролцогчдын 40 орчим хувь нь дунд зэрэг гэж хариулсан, харин бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 50.0 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 80 хувь нь түгээмэл гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан бодлогод оролцогч, шинжээчдийн тоо нь 80 хувьтай байгаа нь 48.4 оноогоор буурахад, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 49.5 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 50 хувь нь, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 43.8 оноогоор, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 16.1 оноогоор буурахад нь дунд зэрэг гэж 70 орчим хувь нь хариулсан нь нөлөөлжээ.
- Харин судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь албан хаагчид нь албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал байдаг гэж үнэлсэн нь 30.6 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 22.7 оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 2.9 оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 12.9 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлжээ.
- Авлигын бодит тохиолдлын сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал 21.6 оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал 38.7 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 80-аас дээш хувь нь мэдэхгүй гэж хариулсан хүчтэй нөлөөлсөн байна.
- Тус байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл 34.1 оноогоор, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл 26.4 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 18. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОУ, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
	БОУ	73.5	44.8	-28.7
	Авлигын талаарх төсөөлөл	79.0	37.5	-41.5
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	82.7	23.3	-59.4
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	87.0	50.0	-37.0
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	76.1	37.5	-38.6
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	75.0	25.0	-50.0
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	86.8	38.3	-48.4
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	87.0	37.5	-49.5
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	77.2	33.3	-43.8
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	66.1	50.0	-16.1
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	72.9	42.3	-30.6
	Авлигыг хянах механизмын үзүүлэлт	51.7	38.9	-12.8
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	51.0	28.3	-22.7
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	39.5	36.5	-2.9
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	64.7	51.8	-12.9
	Авлигын бодит тохиолдол	96.2	66.1	-30.1
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал	96.6	75.0	-21.6
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	95.8	57.1	-38.7

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл		67.0	36.8	-30.2
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	71.6	37.5	-34.1
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	62.5	36.1	-26.4

5. Говьсүмбэр аймгийн ЗДТГ: Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд 2024 онд БОУ нь 40.3 оноотой болж, 2023 оноос 32.7 оноогоор буурч 81 дүгээрт эрэмбэлэгджээ. Энэ байгууллагын хувьд өнгөрсөн жилээс авлигын бодит тохиолдол хамгийн ихээр буурсан буюу 60.4 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 50 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь ийнхүү нөлөөлжээ. Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 53.4 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 40.8 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 45.6 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 50.8 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 50.8 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 32.8 оноогоор буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь судалгаанд оролцогчдын хариулт жигд тархсанд байлаа. Харин албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 30.6 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 50 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь нөлөөлжээ. Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал судалгаанд оролцогчдын 40 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байсан ч, тус үзүүлэлт 13.9 оноогоор өсч үнэлэгдсэн нь тухайн байгууллагын хувьд эерэг үзүүлэлт байлаа.

Хүснэгт 19. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын БОУ, түүний дэд үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
БОУ		73.0	40.8	-32.2
Авлигын талаарх төсөөлөл		87.2	48.9	-38.3
A1	Тухайн байгууллагад авлига хэр түгээмэл байна вэ?	94.8	57.7	-37.1
A2	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал	95.7	42.3	-53.4
A3	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал	90.8	50.0	-40.8
A4	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал	93.3	47.7	-45.6
A5	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал	96.3	45.5	-50.8
A6	Албан хаагчид нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал	96.7	45.8	-50.8
A7	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал	96.4	63.6	-32.8
A8	Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал	23.6	37.5	13.9
A9	Албан хаагчид нь албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал	97.0	50.0	-47.0
Авлигыг хянах механизмын үзүүлэлт		51.4	33.1	-18.3
A10	Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал	50.0	31.3	-18.8
A11	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал	48.0	32.5	-15.5
A12	Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал	56.3	35.4	-20.8
Авлигын бодит тохиолдол		97.9	37.5	-60.4
A13	Та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор	100.0	50.0	-50.0

№	Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
	нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн байдал			
A14	Албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан байдал	95.8	25.0	-70.8
Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл		57.6	41.7	-15.9
A15	Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	56.0	48.1	-8.0
A16	Дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл	55.2	35.4	-19.8

Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдлуудын хувьд судалгаанд оролцогчдын 30 хувь нь мэдэхгүй байгаа нь нөлөөлжээ. Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэлээс илүү дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл илүү үр дүнтэй байдаг гэж бодлогод оролцогчид үнэлжээ.

БҮЛЭГ 3: МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ


Энэхүү бүлэгт Монгол Улс дахь авлигын шалтгаан, нөхцөл, авлига хамгийн их тархсан институцийн талаар, ирэх 2 жилд авлигын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл болон АТГ-ын үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний үр дүнгүүдийг орууллаа.

3.1 Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээний бодлогод оролцогч, шинжээчдээс авах судалгааны нэг хэсэг нь Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал хэр байгаа талаар тодруулах асуулт байдаг бөгөөд асуултын үр дүнг дараах графикаар харууллаа.

2024 онд судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчдийн 60.2 хувь нь ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан байгаагаас харахад 10 шинжээч тутмын 6 нь Монгол улсад авлига ихээхэн түгээмэл, түгээмэл байна гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 23 хувь нь дунд зэрэг, 5.6 хувь нь бага зэрэг, 2.1 хувь нь огт байхгүй, 9.1 хувь нь мэдэхгүй/хариулаагүй гэж үзжээ. 2024 оны Монгол улсын авлигын өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг 5 жилийн харьцуулсан үр дүнгээс харахад Монгол улсад авлига ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан хувь нь 2019 оноос 9.3 пунктээр, 2021 оны үзүүлэлтээс 7.5 пунктээр, 2022 оны үзүүлэлтээс 6.9 пунктээр, 2023 оны үзүүлэлтээс 16.4 пунктээр тус тус доогуур байгаагаас харахад бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд Монгол улс дахь авлигын нөхцөл байдал сайжирч байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, өмнөх жилээс ихээхэн түгээмэл, түгээмэл гэж үзсэн оролцогчдын хувь буурсан байгаагаас харагдаж байна.

График 4. Монгол улс дахь авлигын өнөөгийн нөхцөл байдал, хувиар



2023 онтой харьцуулахад мэдэхгүй/хариулаагүй гэж хариулсан бодлогод, оролцогч шинжээчдийн тоо 5.2 пунктээр өсчээ.

3.2 Монгол улс дахь авлига хамгийн их тархсан институц

Судалгаанд оролцогч шинжээчдийн үзэж байгаагаар Монгол улсад авлига хамгийн их тархсан 5 институцээр “Шүүхийн байгууллага”, “Газрын алба”, “Эрүүл мэндийн байгууллага”, “Улс төрийн нам”, “Гаалийн байгууллага” гэж нэрлэсэн нь 2023 оны авлига хамгийн их тархсан 5 институц хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал, “Шүүхийн

байгууллага” гэж судалгаанд оролцогчдын 40.8 хувь нь хариулсан бөгөөд өмнөх оноос 20.99 пунктээр буурсан ч, “Шүүхийн байгууллага” нь авлига хамгийн их тархсан институцийг тэргүүлсэн хэвээр байна. “Газрын алба” нь мөн авлига хамгийн их тархсан институцийн хоёрдугаарт эрэмбэлэгдэж, 2023 оны эрэмбийг хадгалсан хэвээр байна. “Эрүүл мэндийн байгууллага” гэж судалгаанд оролцогчдын 39.28 хувь хариулсан нь өмнөх онтой харьцуулахад 8.35 пунктээр буурч, гуравдугаарт эрэмбэлэгджээ. Монгол улсад авлига тархаж байгаа шалтгаануудыг цалин хөлс бага, ядуурал их, амьжиргааны түвшин доогуур байгаа байдал, мөн хувь хүний ёс суртахуун дорой байгаа байдал, мөн хариуцлага тооцдоггүй байдалтай холбон тайлбарласан байна. Эдгээр зүйлс байгаа учраас өнөөдөр Монгол улсад авлига буурахгүй байна гэж бодлогод оролцогч, шинжээчид үзжээ.

Хүснэгт 20. Монгол улсад авлига хамгийн их тархсан институц, хариултад эзлэх хувиар

№	Институцийн төрөл	2022	2023	2024	2024 оны эрэмбэ
1	Шүүх	50.2	61.77	40.78	I
2	Газрын алба	52.5	57.98	39.35	II
3	Эрүүл мэндийн байгууллага	52.9	47.63	39.28	III
4	Улс төрийн нам	39.5	46.26	36.14	IV
5	Гаалийн байгууллага	47.2	48.99	29.02	V
6	Боловсролын байгууллага	41.1	32.12	28.17	VI
7	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	45.7	45.71	27.39	VII
8	Цагдаагийн байгууллага	35.2	35.81	26.34	VIII
9	Нутгийн захиргааны байгууллага	22.7	32.73	25.62	IX
10	Прокурорын байгууллага	42.8	45.71	22.03	X
11	Татварын байгууллага	28.5	22.78	20.33	XI
12	Хэвлэл мэдээллийн байгууллага	22.1	28.48	20.00	XII
13	Төрийн бус байгууллага	10.3	10.3	8.89	XIII
14	Хувийн хэвшил	7.9	11.82	8.82	XIV

Гэвч бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд үзэж байгаагаар авлигыг бууруулахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- Сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг байх, түгээх гэж 18.4 хувь,
- Үйл ажиллагааг ил тод байлгах, нээлттэй түгээдэг байх 13.4 хувь,
- Цалин хөлсийг нэмэгдүүлж, хангалттай түвшинд байлгах 10.6 хувь
- Хяналт шалгалтын ажлыг хийх, сайжруулах, тогтмолжуулах, чангатгах 9.2 хувь,
- Мэргэжлийн ёс зүй, хувь хүний шударга байдлыг баримтлах 8 хувь,
- Хариуцлагын тогтолцоог сайжруулж, хариуцлага тооцдог байх 7.5 хувь,
- Хуулийг баримталдаг байх 6.6 хувь,
- Цахимжуулах, үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах 5.8 хувь,
- Чадварлаг боловсон хүчинтэй байх, сонгон шалгаруулалтыг зөв зохион байгуулдаг байх 3.3 хувь
- Намын томилгоо, улс төрөөс ангид байх 2 хувь,
- Төрийн албан хаагчийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, дараалал үүсгэдэггүй байх 1.3 хувь,
- Танил талын нөлөөг байхгүй болгох, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах 2.4 хувь зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулснаар авлигыг бууруулна гэж үзжээ.
- Харин судалгаанд оролцогчдын 6.1 хувь санал байхгүй, 4.6 хувь нь хариулаагүй байна.

График 5. Бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд авлигыг бууруулах, албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай зүйлс



3.3 Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан нөхцөл

Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан нөхцөлийг (хамгийн их сонголтоос нь хамгийн бага сонголт руу нь эрэмбэлэн бичив) ядуурал, амьжиргааны түвшин доогуур байгаа байдал, цалин хөлс бага, хувь хүний ёс зүй, хандлага муу байгаа байдал, хариуцлага тооцдоггүй байдал, төрийн албанд нам улс төрийн оролцоо их, хууль байвч хуулиа мөрддөггүй байдал, төрийн байгууллагын хүнд суртал, буруу тогтолцоо, ил тод бус байдал, төрийн албан хаагчдын танил тал, хамаатан садны холбоо, эрх мэдлээ урвуулан ашиглах байдал, хяналт сул байгаа байдал, боловсролын тогтолцоо муу, иргэдийн боловсролын доогуур түвшин, ажлаа хурдан бүтээх гэсэн хандлага, цахим үйлчилгээ нэвтрээгүй байдал, АТГ-ын үйл ажиллагааны сул байдал зэрэг нь авлигын үндсэн шалтгаан нөхцөл болж байна гэж үзжээ. Тиймээс эдгээр шалтгаан нөхцөлүүдийг сайжруулснаар Монгол улс дах авлигын хэмжээ буурах боломжтой.


График 6. Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан, нөхцөл, хариултад эзлэх хувиар



3.4 Ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл

Ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар судалгаанд оролцогчдын төсөөллийг асуухад судалгаанд оролцогчдын 32.9 хувь нь өөрчлөгдөхгүй энэ хэвээр байна, 18.8 хувь буурна, 17.8 хувь нь өснө, 3.9 хувь их өснө, 2.7 хувь их буурна, 23.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.


График 7. Ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх төсөөлөл



3.5 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх вэ? Гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 39.7 хувь нь дунд зэрэг, 18.8 хувь нь үр ашигтай, 15.6 хувь нь үр ашиггүй, 7.4 хувь нь огт үр ашиггүй, 2.6 хувь нь ихээхэн үр ашигтай, 16 хувь нь мэдэхгүй байна гэж хариулжээ. 2023 онтой харьцуулахад ихээхэн үр ашигтай, үр ашигтай, дунд зэрэг гэсэн хариултууд 0.9-9.4 пунктээр буурсан бол, үр ашиггүй, огт үр ашиггүй, мэдэхгүй байна гэсэн хариултууд 1.0-3.3 пунктээр өсчээ.

График 8. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар



ДҮГНЭЛТ

Монгол улс 2006 онд Авлигын эсрэг хуулийг баталж, энэхүү хуулийн хүрээнд Авлигатай тэмцэх газар “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гарган, олон нийтэд мэдээлэх”, мөн төрийн байгууллагуудын шударга байдлыг үнэлж олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээдэг. Энэхүү үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх газар нь 2015 оноос эхлэн төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний судалгааг 2 жил тутам дараалан хийж, судалгааны үр дүнг олон нийтэд мэдээлсээр иржээ.

Шударга байдлын үнэлгээ нь гадаад болон дотоод шударга байдал, бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг бөгөөд 2024 онд төрийн байгууллагуудын шударга байдлын талаар бодлогод оролцогчид, шинжээчдээс авсан судалгааны тайлангийн үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг өгч байна. Үүнд:

- БОУ нь 2024 онд 67.1 болж, 2023 онтой харьцуулахад 6.6 оноогоор буурч үнэлэгджээ. Ийнхүү буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 7.9 оноогоор, авлигыг хянах механизм 6.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.6 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна.
- БОУ-ээр төрийн 16 яамнаас 3 яамны БОУ өсч (6.9-8.8 оноогоор ↑) үнэлэгдсэн бол, 13 яамны БОУ буурч (1.3-28.4 оноогоор ↓) үнэлэгдсэн, 33 агентлагаас 9 агентлагийн үнэлгээ өсч (0.6-15.5↑) үнэлэгдсэн бол, 24 агентлагийн үнэлгээ буурч (0.8-27.5↓) үнэлэгдсэн бол, 8 аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ өсч (0.1-18.7↑) үнэлэгдсэн бол, 15 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ буурч (0.6-32.7↓) үнэлэгджээ.
- Авлигын бодит тохиолдлын шударга байдлын үнэлгээ нь БОУ-ний бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад өндөр байгаа бол, авлигыг хянах механизмын шударга байдлын үнэлгээ нь бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага байна. БОУ-ний дэд үзүүлэлтүүдийн хувьд 2024 оны авлигын талаарх төсөөлөл 68.6 оноотой болж, 2023 онтой харьцуулахад 7.8 оноогоор, авлигыг хянах механизм 49.8 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад 6.7 оноогоор, авлигын бодит тохиолдол 90 оноотой болж, өмнөх оноос 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 59.9 оноотой болж, өмнөх оноос 4.5 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.
- БОУ-г Хууль зүй, дотоод хэргийн яам 88.5 оноотой тэргүүлсэн бол, Говьсүмбэр аймгийн ЗДТГ 40.3 оноотой хамгийн сүүлд эрэмбэлэгдлээ. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд:

- Авлигын бодит тохиолдол хамгийн ихээр өсч үнэлэгдсэн буюу 60.4 оноогоор өссөн нь судалгаанд оролцогчдын 50 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсантай холбоотой байлаа.
- Авлигын талаарх төсөөлөл түүн дотроо албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 53.4 оноогоор, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал 40.8 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал 45.6 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах явдал 50.8 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал 50.8 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй/хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал

32.8 оноогоор, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал 47.0 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн бөгөөд Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд эдгээр үзүүлэлтүүд дээр маш сайн ажиллах шаардлагатайг харуулж байна.

- Авлигыг хянах механизм түүн дотроо авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал хамгийн муу буюу 20.8 оноогоор буурч үнэлэгджээ.
- Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд удирдлагаас илүү дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлэл нь бага үнэлэгдсэн байна. Тиймээс цаашид үүнийг анхаарч ажиллах шаардлагатай байна.
- БОУ-ний дэд үзүүлэлтүүдийг байгууллагын төрлөөр авч үзвэл дүүргүүдийн ЗДТГ-уудын авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр буурсан бол, авлигыг хянах механизм яамдуудын хувьд хамгийн ихээр буурсан, авлигын бодит тохиолдол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд хамгийн ихээр буурсан, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл яамдуудын хувьд хамгийн ихээр бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад тус тус буурчээ. Тухайлбал,
 - Авлигын талаарх төсөөлөл Боловсрол, шинжлэх ухааны яамны хувьд хамгийн их бууралттай байгаа бол, агентлагуудын хувьд Үндэсний геологийн алба хамгийн их бууралттай, аймаг, нийслэлийн хувьд Баянхонгор аймгийн ЗДТГ, Багахангай дүүргийн ЗДТГ зэрэг байгууллагууд хамгийн их бууралттай буюу 35.3-51.4 оноогоор буурч үнэлэгджээ. Тухайлбал, Үндэсний геологийн албын хувьд БОУ нь 27.5 оноогоор буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд: Тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл (35.3↓), авлигыг хянах механизм (6.4↓), авлигын бодит тохиолдол (47.3↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (20.9↓) буурч үнэлэгджээ. БОУ-г бууруулахад нөлөөлж байгаа үзүүлэлтүүдийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (44.7 ↓), ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал (39.7↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (50.1 ↓), бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (44.0↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (59.3↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (38.1 ↓), бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал (47.0 ↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (25.0 ↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал (8.3 ↓), шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй байдал (27.1↓), авлигын бодит тохиолдол (47.3 ↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (26.0↓), дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (15.8↓) буурсан нь нөлөөлжээ.
 - Авлигыг хянах механизмын хувьд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 34.5 оноогоор, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газар 31.9

- оноогоор, Говь-Алтай аймгийн ЗДТГ 26.5 оноогоор, Чингэлтэй дүүргийн ЗДТГ 22 оноогоор тус тус буурсан нь хамгийн их бууралт байв.
- Авлигын бодит тохиолдлын хувьд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 51.6 оноогоор, Үндэсний геологийн алба 47.3 оноогоор, Говьсүмбэр аймгийн ЗДТГ 60.4 оноогоор, Чингэлтэй дүүргийн ЗДТГ 41.0 оноогоор тус тус буурсан нь хамгийн их бууралт байв.
 - Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийн хувьд Боловсрол, шинжлэх ухааны яам 37.7 оноогоор, ашигт малтмал газрын тосны газар 23.4 оноогоор, Баянхонгор аймгийн ЗДТГ 30.2 оноогоор, Чингэлтэй дүүргийн ЗДТГ 22.3 оноогоор тус тус буурсан нь хамгийн их бууралтыг эзэлж байв.
- Судалгаанд оролцогч нийт шинжээчдийн 43.6 хувь нь Монгол улсад авлига “Түгээмэл” байна гэж хариулсан бол, ирэх 2 жилд авлигын түвшин өөрчлөгдөхгүй хэвээр байна гэж 32.9 хувь нь хариулжээ.
 - Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар Монгол улсад авлига хамгийн их тархсан 5 институцэд “Шүүх”, “Газрын алба”, “Эрүүл мэндийн байгууллага”, “Улс төрийн нам”, “Гаалийн байгууллага” гэж үзсэн нь 2023 онтой харьцуулахад эхний 5 байрт эрэмбэлэгдсэн институциуд хадгалагдсан хэвээр байна.
 - Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан нөхцөлийг
 - Ядуурал, амьжиргааны түвшин доогуур байгаа байдал, цалин хөлс бага
 - Хувь хүний ёс зүй хандлага муу, хариуцлага тооцдоггүй байдал,
 - Нам улс төрийн оролцоо их байгаа байдал,
 - Хуулиа дагаж мөрддөггүй байдал, төрийн байгууллагуудын хүнд суртал
 - Ил тод бус байдал, хяналт сул,
 - Төрийн байгууллагад танил тал, хамаатан садны холбоо их, эрх мэдлээ урвуулан ашиглах байдал, цахим үйлчилгээ бүрэн нэвтрээгүй байдал, АТГ-ын үйл ажиллагааны үр дүн муу байгаа байдал зэрэг гэж үзжээ. Тиймээс цаашид төрийн байгууллагууд эдгээр зүйлс дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.
 - Харин Монгол улс дах төрийн байгууллагуудын авлигыг бууруулахын тулд сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулах, төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа нээлттэй ил тод байлгах, цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлж, хангалттай түвшинд байлгах, хяналт шалгалтыг сайжруулж, тогтмолжуулах, мэргэжлийн ёс зүй, хувь хүний шударга байдлыг баримтлах, хуулийг баримтлах, сахих, улс төрийн томилгоо, намаас ангид үйл ажиллагаагаа явуулдаг байх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зэрэг ажлуудыг зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзжээ.
 - Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг судалгаанд оролцогчдын 39.7 хувь нь “Дунд зэрэг” хэмээн дүгнэжээ.

ХАВСРАЛТ

Хавсрлт 1. Түүврийн хэмжээ, байгууллагын төрлөөр

№	Байгууллага	Шинжээчдээс авах
	Яамд	400
1	Байгал орчин аялал жуулчлалын яам	25
2	Барилга хот байгуулалтын яам	25
3	Батлан хамгаалах яам	25
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	25
5	Гадаад харилцааны яам	25
6	Зам, тээвэр хөгжлийн яам	25
7	Сангийн яам	25
8	Соёлын яам	25
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	25
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	25
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	25
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	25
13	Эрүүл мэндийн яам	25
14	Эрчим хүчний яам	25
15	Эдийн засаг хөгжлийн яам	25
16	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	25
	Агентлаг	680
17	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	20
18	Онцгой байдлын ерөнхий газар	20
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	20
20	Стандарт, хэмжил зүйн газар	20
21	Цаг уур, орчны шинжилгээний газар	20
22	Гаалийн ерөнхий газар	20
23	Татварын ерөнхий газар	20
24	Цагдаагийн ерөнхий газар	20
25	Улсын бүртгэлийн ерөнхий газар	20
26	Архивын ерөнхий газар	20
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	20
28	Гадаадын иргэн харьяатын газар	20
29	Нийгмийн даатгалын ерөнхий газар	20
30	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	20
31	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	20
32	Газар зохион байгуулалт, геодиз, зураг зүйн газар	20
33	Биеийн тамир, спортын улсын хороо	20
34	Соёл урлагийн газар	20
35	Иргэний нисэхийн ерөнхий газар	20
36	Ашигт малтмал, газрын тосны газар	20
37	Мал эмнэлгийн ерөнхий газар	20
38	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	20
39	Оюуны өмчийн газар	20
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	20
41	Төрийн худалдан авах ажиллагааны газар	20
42	Усны газар	20
43	Үндэсний геологийн алба	20
44	Жижиг, дунд үйлдвэрийн газар	20
45	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	20
46	Боловсролын ерөнхий газар	20
47	Ойн газар	20
48	Шүүх шинжилгээний ерөнхий газар	20
49	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	20
50	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	20
	Аймгийн засаг даргын тамгын газар	450
51	Архангай аймгийн ЗДТГ	15
52	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	15
53	Баянхонгор аймгийн ЗДТГ	15
54	Булган аймгийн ЗДТГ	15
55	Говь-Алтай аймгийн ЗДТГ	15
56	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	15
57	Дархан-Уул аймгийн ЗДТГ	15

58	Дорноговь аймгийн ЗДТГ	15
59	Дорнод аймгийн ЗДТГ	15
60	Дундговь аймгийн ЗДТГ	15
61	Завхан аймгийн ЗДТГ	15
62	Орхон аймгийн ЗДТГ	15
63	Өвөрхангай аймгийн ЗДТГ	15
64	Өмнөговь аймгийн ЗДТГ	15
65	Сүхбаатар аймгийн ЗДТГ	15
66	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	15
67	Төв аймгийн ЗДТГ	15
68	Увс аймгийн ЗДТГ	15
69	Ховд аймгийн ЗДТГ	15
70	Хөвсгөл аймгийн ЗДТГ	15
71	Хэнтий аймгийн ЗДТГ	15
72	Нийслэлийн ЗДТГ	20
73	Багануур дүүргийн ЗДТГ	5
74	Багахангай дүүргийн ЗДТГ	5
75	Баянгол дүүргийн ЗДТГ	15
76	Баянзүрх дүүргийн ЗДТГ	15
77	Налайх дүүргийн ЗДТГ	15
78	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	15
79	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	15
80	Хан-Уул дүүргийн ЗДТГ	15
81	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	15
	Нийт	1530

Хавсралт 2. БОУ-ний дэлгэрэнгүй үр дүн

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
Яамдын БОУ		69.8	49.4	92.4	62.7	68.6
1	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	74.4	53.4	88.0	66.2	70.5
2	Барилга хот байгуулалтын яам	97.1	32.4	100.0	75.6	76.3
3	Батлан хамгаалах яам	90.9	69.6	100.0	78.7	84.8
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	35.3	34.1	92.3	35.0	49.2
5	Гадаад харилцааны яам	82.2	56.1	100.0	75.6	78.5
6	Зам, тээвэр хөгжлийн яам	58.2	39.7	100.0	62.0	65.0
7	Сангийн яам	73.3	47.2	95.0	69.4	71.2
8	Соёлын яам	82.4	65.0	100.0	72.6	80.0
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	44.9	44.5	48.4	43.9	45.4
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	66.7	52.8	100.0	64.7	71.1
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	86.3	81.2	100.0	86.6	88.5
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	65.6	36.0	95.1	49.3	61.5
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	79.1	40.6	100.0	63.7	70.8
14	Эдийн засаг хөгжлийн яам	53.0	45.0	78.2	53.1	57.3
15	Эрүүл мэндийн яам	70.4	44.7	100.0	56.1	67.8
16	Эрчим хүчний яам	56.2	48.4	81.0	50.7	59.1
Агентлагуудын БОУ		72.1	53.1	93.2	61.4	69.9
17	Архивын ерөнхий газар	69.4	49.0	96.7	59.4	68.6
18	Ашигт малтмал, газрын тосны газар	47.8	45.8	55.7	47.1	49.1
19	Биеийн тамир, спортын улсын хороо	75.7	50.2	97.1	62.6	71.4
20	Боловсролын ерөнхий газар	63.0	44.4	100.0	54.0	65.4
21	Гаалийн ерөнхий газар	47.0	42.3	79.0	54.2	55.6
22	Гадаадын иргэн харьяатын газар	77.4	56.9	100.0	66.4	75.2
23	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	62.6	35.4	100.0	48.4	61.6
24	Жижиг, дунд үйлдвэрийн газар	92.5	48.6	100.0	79.5	80.1
25	Иргэний нисэхийн ерөнхий газар	58.4	39.3	94.4	44.0	59.0
26	Мал эмнэлгийн ерөнхий газар	77.8	48.6	100.0	63.2	72.4
27	Нийгмийн даатгалын ерөнхий газар	65.8	48.3	100.0	51.9	66.5
28	Ойн газар	76.0	59.5	89.9	59.5	71.3
29	Онцгой байдлын ерөнхий газар	79.1	53.8	100.0	63.1	74.0
30	Оюуны өмчийн газар	83.3	66.6	97.2	76.3	80.9
31	Соёл урлагийн газар	83.2	58.9	96.9	68.3	76.8
32	Стандарт, хэмжил зүйн газар	76.4	62.3	100.0	68.9	76.9
33	Татварын ерөнхий газар	70.1	51.1	100.0	58.9	70.0
34	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	76.1	49.3	96.9	71.7	73.5
35	Төрийн худалдан авах ажиллагааны газар	67.9	49.0	80.6	58.3	63.9
36	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	74.3	64.6	94.1	71.1	76.0
37	Улсын бүртгэлийн ерөнхий газар	78.0	61.6	100.0	59.4	74.7
38	Усны газар	80.7	64.6	100.0	56.3	75.4
39	Үндэсний геологийн алба	45.8	47.9	52.7	46.0	48.1
40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	79.5	42.7	96.9	57.8	69.2

№	Байгууллагын нэр	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	БОУ
Яамдын БОУ		69.8	49.4	92.4	62.7	68.6
41	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	73.7	57.8	100.0	54.2	71.4
42	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	72.5	42.9	92.5	60.0	67.0
43	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	79.9	46.3	100.0	67.4	73.4
44	Цаг уур, орчны шинжилгээний газар	61.4	48.0	80.0	56.0	61.3
45	Цагдаагийн ерөнхий газар	75.6	53.8	97.2	62.1	72.2
46	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	75.8	51.0	87.9	66.7	70.3
47	Шүүх шинжилгээний ерөнхий газар	82.2	58.5	97.1	75.0	78.2
48	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	88.1	78.9	97.5	78.9	85.9
49	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	59.8	59.4	100.0	58.8	69.5
50	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	74.1	67.0	87.1	61.7	72.5
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ		64.1	44.8	83.9	55.9	62.2
51	Архангай аймгийн ЗДТГ	62.0	55.8	100.0	56.8	68.6
52	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	77.0	41.4	100.0	51.0	67.3
53	Баянхонгор аймгийн ЗДТГ	37.5	38.9	66.1	36.8	44.8
54	Булган аймгийн ЗДТГ	73.2	53.8	84.0	70.5	70.4
55	Говь-Алтай аймгийн ЗДТГ	53.8	31.1	81.8	50.0	54.2
56	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	48.9	33.1	37.5	41.7	40.3
57	Дархан-Уул аймгийн ЗДТГ	55.9	42.3	75.6	51.8	56.4
58	Дорноговь аймгийн ЗДТГ	87.7	56.7	96.2	79.1	79.9
59	Дорнод аймгийн ЗДТГ	47.2	32.1	86.4	43.2	52.2
60	Дундговь аймгийн ЗДТГ	58.2	48.9	89.5	50.0	61.7
61	Завхан аймгийн ЗДТГ	60.4	46.5	66.4	56.4	57.4
62	Орхон аймгийн ЗДТГ	71.8	51.6	78.5	58.5	65.1
63	Өвөрхангай аймгийн ЗДТГ	74.3	51.0	100.0	65.0	72.5
64	Өмнөговь аймгийн ЗДТГ	59.4	47.2	94.4	55.2	64.1
65	Сүхбаатар аймгийн ЗДТГ	49.8	41.9	56.1	44.2	48.0
66	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	68.1	51.2	84.6	57.8	65.4
67	Төв аймгийн ЗДТГ	95.5	62.1	100.0	79.7	84.3
68	Увс аймгийн ЗДТГ	66.6	33.4	100.0	51.1	62.8
69	Ховд аймгийн ЗДТГ	53.7	44.6	70.3	48.9	54.4
70	Хөвсгөл аймгийн ЗДТГ	65.0	34.3	96.7	71.2	66.8
71	Хэнтий аймгийн ЗДТГ	55.3	40.2	81.9	47.5	56.2
72	Нийслэлийн ЗДТГ	88.7	48.7	100.0	62.9	75.1
Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ		64.7	50.2	88.6	58.7	65.6
73	Багануур дүүргийн ЗДТГ	80.0	45.8	100.0	60.0	71.5
74	Багахангай дүүргийн ЗДТГ	30.6	72.2	100.0	62.5	66.3
75	Баянгол дүүргийн ЗДТГ	58.9	53.4	78.0	57.7	62.0
76	Баянзүрх дүүргийн ЗДТГ	77.3	51.0	100.0	67.3	73.9
77	Налайх дүүргийн ЗДТГ	73.3	43.2	100.0	57.7	68.6
78	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	46.0	42.7	70.7	50.0	52.4
79	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	72.1	52.5	93.3	52.5	67.6
80	Хан-Уул дүүргийн ЗДТГ	86.7	57.4	96.7	72.0	78.2
81	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	57.6	33.7	59.0	49.0	49.8

Хавсралт 3. БОУ-ний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

	Байгууллагын нэр	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
1	Архивын ерөнхий газар	-14.7	-23.2	-19.7	-23.3	-26.6	-31.4	-24.6	17.6	-2.3	-19.6	-16.9	-11.9	0.0	-6.7	-10.0	-9.6
2	Ашигт малтмал, газрын тосны газар	-40.2	-30.8	-35.5	-41.0	-36.8	-52.2	-33.3	41.7	-22.0	-5.6	-7.5	-20.5	-35.3	-53.3	-25.6	-21.3
3	Биеийн тамир, спортын улсын хороо	14.4	14.1	25.2	29.6	20.8	13.8	4.2	8.2	-16.8	11.8	6.4	3.0	0.0	-5.9	12.2	7.9
4	Боловсролын ерөнхий газар	-33.8	-29.9	-31.3	-27.5	-37.8	-35.3	-34.6	1.3	-34.9	-39.4	-39.6	-13.1	0.0	0.0	-11.4	-26.7
5	Гаалийн ерөнхий газар	-18.5	-26.3	5.7	0.3	-13.3	8.1	3.1	10.7	-10.9	-10.8	4.4	-12.5	-16.7	-9.8	-3.9	1.9
6	Гадаадын иргэн, харьяатын газар	-21.2	-22.4	-15.2	-10.5	-13.2	-18.4	-11.8	2.5	-10.1	-11.7	-19.5	-23.2	0.0	0.0	-11.0	-19.7
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	-22.1	-21.6	-13.8	-9.2	-29.5	-40.4	-25.3	18.8	-35.4	-37.2	-46.3	-12.3	0.0	0.0	-11.6	-32.8
8	Жижиг, дунд үйлдвэрийн газар	6.7	-6.3	9.5	3.5	-9.3	-3.4	-4.2	28.1	1.3	-27.7	-15.9	11.1	0.0	0.0	3.8	17.3
9	Иргэний нисэхийн ерөнхий газар	-3.3	4.2	6.6	-0.8	-2.2	5.9	15.2	-2.1	12.0	12.8	1.9	3.4	-11.1	7.1	-4.2	-1.1
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	12.3	3.9	30.4	9.2	-13.2	7.5	6.5	10.9	10.9	1.8	-11.0	-5.2	0.0	0.0	13.9	16.5
11	Нийгмийн даатгалын ерөнхий газар	21.1	30.8	24.0	11.0	22.9	27.9	25.7	19.1	38.2	2.7	4.6	16.3	11.8	6.7	0.2	-3.2
12	Ойн газар	-1.4	4.5	-4.6	-0.7	-7.1	19.0	2.9	12.3	-8.3	-10.9	-1.4	-9.6	-5.9	-14.3	-13.1	-16.3
13	Онцгой байдлын ерөнхий газар	-3.5	-9.8	-1.6	4.4	-1.5	2.2	-3.4	-49.5	6.3	-7.7	-18.2	-4.3	5.0	7.1	2.2	0.4
14	Оюуны өмчийн газар	-1.2	-8.6	19.7	6.7	-8.7	-9.5	-8.4	38.3	-4.3	4.7	1.5	12.5	0.0	-5.6	18.8	13.9
15	Соёл, урлагийн газар	4.5	-2.2	0.0	16.9	0.0	12.1	-2.0	2.1	12.0	-8.2	-7.8	-2.3	-6.3	0.0	1.7	3.3
16	Стандарт, хэмжил зүйн газар	-17.2	-10.3	-23.3	-26.7	-16.5	-20.3	-14.2	8.9	-7.5	0.4	-28.8	-11.1	0.0	0.0	-9.1	-4.5
17	Татварын ерөнхий газар	-14.4	-9.9	-4.6	-7.8	-1.2	-2.0	-6.9	-15.0	-6.1	0.2	-5.4	-11.7	0.0	5.3	-13.0	-12.3
18	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	-11.8	-16.9	-1.9	-21.9	-16.7	-21.9	-18.3	45.3	-7.8	-39.8	-14.5	-7.8	0.0	-1.0	1.3	-0.4
19	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-8.4	-26.6	-5.6	-16.3	-14.0	-26.4	-28.8	-40.4	-21.3	-22.6	-13.2	-19.3	-22.2	-16.7	-15.1	-20.7
20	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	0.4	-9.0	-6.9	-7.8	-20.0	-17.6	-20.1	-14.2	-19.5	9.3	-4.2	-4.0	4.6	-5.9	-6.3	-1.6
21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	-11.7	11.3	-12.5	-7.5	10.0	-15.9	-4.2	19.6	-1.9	0.0	0.4	-7.6	0.0	27.8	-13.9	-13.6
22	Усны газар	26.3	12.9	18.6	22.5	6.3	21.1	5.2	20.0	17.9	28.3	12.9	2.5	5.0	0.0	-3.5	-5.0
23	Үндэсний геологийн алба	-63.8	-44.7	-39.7	-50.1	-44.0	-59.3	-38.1	47.0	-25.0	-8.3	16.1	-27.1	-41.2	-53.3	-26.0	-15.8
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	7.7	-6.8	-7.2	-10.9	-1.9	-8.3	0.5	6.9	-13.8	-20.8	-17.3	-11.2	-1.0	11.1	-3.1	-18.1
25	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	-35.7	-9.2	-15.3	-26.7	-25.0	-18.2	-26.1	42.4	-13.7	-15.4	-7.9	-14.6	0.0	0.0	-17.5	-24.2
	Хөрөнгө оруулалт, худалдааны газар																
26	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	14.6	2.9	48.8	54.2	9.4	54.2	40.1	-9.6	32.1	-20.6	-0.2	21.9	0.0	0.0	20.3	22.5

	Байгууллагын нэр	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
27	Цаг уур, орчны шинжилгээний газар	-18.8	8.1	-15.8	-15.0	-27.3	-9.9	-15.2	1.2	-15.0	4.2	18.3	7.9	-14.7	-20.0	20.7	11.2
28	Цагдаагийн ерөнхий газар	-22.1	6.8	9.7	-13.5	-8.3	-7.1	2.1	4.2	-4.0	-12.4	8.7	-14.2	5.6	8.7	-14.3	-3.2
29	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	-27.8	-17.2	-10.0	-22.2	-17.0	-15.8	-6.7	-2.9	-13.9	-15.1	-5.6	-17.9	-11.8	-12.5	-0.4	-17.2
31	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар	-8.1	-13.2	-0.4	-2.7	2.4	1.8	-4.3	45.1	-3.7	2.1	8.0	19.8	0.0	-5.9	24.9	20.2
30	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.0	7.5	7.0	3.8	2.5	-7.5	4.0	-46.3	-3.9	7.9	28.0	5.8	0.0	-5.0	5.4	15.0
32	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-10.8	-22.0	-9.6	-29.7	-33.9	-27.0	-25.0	-8.1	-42.2	-1.1	-20.0	-12.1	0.0	0.0	-10.0	-17.5
33	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	-18.7	-11.7	-16.4	-6.7	-15.0	-6.8	-12.5	-87.5	-42.5	-8.4	-5.4	3.1	-12.5	-13.3	-10.0	-10.3
34	Архангай аймгийн ЗДТГ	-26.0	-14.1	-4.2	-19.1	-32.4	-17.6	-13.9	-59.5	-7.0	21.3	2.9	0.8	3.4	7.4	-3.9	-8.4
35	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	27.0	18.9	42.5	31.7	11.3	19.5	41.8	28.3	13.3	-13.7	-10.0	27.7	6.9	11.5	4.5	6.3
36	Баянхонгор аймгийн ЗДТГ	-59.4	-37.0	-38.6	-50.0	-48.4	-49.5	-43.8	-16.1	-30.6	-22.7	-2.9	-12.9	-21.6	-38.7	-34.1	-26.4
37	Булган аймгийн ЗДТГ	9.8	0.4	-2.1	2.2	-1.2	-9.2	-14.7	25.5	-3.1	15.4	-0.3	15.6	-15.4	-13.2	10.4	19.7
38	Говь-Алтай аймгийн ЗДТГ	-26.5	-20.4	-35.4	-31.3	-51.5	-24.9	-41.0	38.0	-20.1	-28.3	-16.5	-34.3	-36.4	0.0	-21.5	-1.4
39	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	-37.1	-53.4	-40.8	-45.6	-50.8	-50.8	-32.8	13.9	-47.0	-18.8	-15.5	-20.8	-50.0	-70.8	-8.0	-19.8
40	Дархан-Уул аймгийн ЗДТГ	5.0	-22.3	-20.5	-0.1	-39.1	-26.9	-15.8	-1.6	-33.0	-19.3	13.7	-10.0	-8.7	-25.9	-18.8	1.8
41	Дорноговь аймгийн ЗДТГ	17.2	15.6	27.5	4.2	12.0	4.1	11.4	37.4	10.1	-7.6	12.2	7.1	0.0	-7.7	8.3	13.9
42	Дорнод аймгийн ЗДТГ	-54.6	-45.2	-39.6	-32.9	-21.1	-16.4	-31.4	19.7	-6.5	-29.5	-26.2	-21.7	-7.1	-15.7	-24.7	-18.5
43	Дундговь аймгийн ЗДТГ	-13.6	-11.3	-31.0	-2.3	-25.6	-7.8	-5.1	-6.2	-19.0	3.5	1.7	6.7	-14.3	-6.7	-16.3	-9.6
44	Завхан аймгийн ЗДТГ	-1.4	-14.6	24.1	-1.2	-18.1	-2.2	-19.0	2.5	-12.4	-8.3	7.7	3.8	-40.0	-27.3	6.5	9.4
45	Орхон аймгийн ЗДТГ	0.2	-2.9	-8.9	-8.0	-6.6	-4.8	-2.8	0.0	-6.9	-15.4	-4.7	-13.4	-12.6	-11.1	-4.5	-13.4
46	Өвөрхангай аймгийн ЗДТГ	-15.9	-9.6	-2.9	-7.6	-8.3	-10.3	-4.4	29.7	-24.9	-15.5	1.1	-3.6	0.0	0.0	-4.6	-2.1
47	Өмнөговь аймгийн ЗДТГ	18.3	1.9	21.4	-2.1	3.1	-4.5	-12.6	1.6	6.0	-22.2	-13.1	7.5	-0.4	4.0	-13.0	3.0
48	Сүхбаатар аймгийн ЗДТГ	-45.8	-43.3	-40.1	-32.9	-33.4	-45.4	-37.7	20.3	-29.5	-26.4	-15.9	-7.5	-41.7	-46.2	-9.7	-13.5
49	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	9.5	-1.7	2.3	4.8	-6.2	-4.1	0.0	11.1	-1.0	7.9	3.0	7.5	-7.7	-9.8	-1.6	-1.3
50	Төв аймгийн ЗДТГ	23.5	21.4	35.2	26.4	15.9	20.1	16.2	55.8	23.3	6.3	22.5	24.5	3.6	8.7	23.0	26.0
51	Увс аймгийн ЗДТГ	6.8	8.3	16.8	4.5	9.8	10.6	18.2	-9.2	5.7	2.4	-13.2	-2.6	12.5	6.3	-2.5	-0.2
52	Ховд аймгийн ЗДТГ	-7.5	-7.0	0.0	4.2	1.1	-4.4	-5.1	15.9	-19.6	4.5	-4.2	10.0	-20.4	-16.6	-12.1	9.9
53	Хөвсгөл аймгийн ЗДТГ	-10.4	-8.9	-4.2	-5.5	-10.9	-8.0	2.0	11.4	-4.3	-17.0	-29.0	2.4	3.7	6.9	13.4	14.3
54	Хэнтий аймгийн ЗДТГ	-11.0	-11.6	14.1	0.8	-8.3	-0.4	-3.3	0.6	2.2	2.8	6.8	-4.7	-28.6	-7.7	-11.3	-2.3
55	Нийслэлийн ЗДТГ	10.3	-2.7	15.2	12.7	13.2	4.9	10.4	53.8	4.3	0.8	-8.9	0.1	0.0	4.3	-8.8	-4.5
56	Багануур дүүргийн ЗДТГ	-14.6	-12.5	6.8	10.4	-0.8	14.6	-2.1	32.5	5.0	3.4	17.5	-9.0	0.0	0.0	4.2	6.4
57	Багахангай дүүргийн ЗДТГ	-93.8	-28.6	-20.3	-82.1	-71.4	-25.0	-91.1	-10.7	-25.8	26.7	23.2	10.3	5.3	0.0	-4.7	-1.8
58	Баянгол дүүргийн ЗДТГ	-30.1	-40.1	-9.5	-21.2	-32.9	-26.3	-33.2	4.3	-15.2	-13.4	-1.8	-2.7	-27.3	-16.7	-2.1	-2.1
59	Баянзүрх дүүргийн ЗДТГ	-16.7	-16.5	-11.8	-5.1	-14.6	-16.1	-6.9	35.3	-15.3	-11.4	-19.6	-2.9	0.0	11.8	4.2	-3.4
60	Налайх дүүргийн ЗДТГ	-12.9	2.7	2.9	11.9	-8.6	-2.7	2.1	-73.4	2.9	0.0	-23.2	-3.3	5.0	0.0	-8.0	-18.6
61	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	-52.8	-37.5	-23.2	-35.7	-39.6	-37.5	-27.3	5.5	-25.1	-5.4	-7.9	-9.1	-36.4	-9.7	-20.6	-15.0
62	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	-28.1	1.7	-21.3	-22.4	-16.1	-26.5	-23.6	5.6	-14.7	22.3	-16.7	-15.8	-6.7	-6.7	-15.8	-14.7
63	Хан-уул дүүргийн ЗДТГ	35.0	32.9	25.7	41.5	24.8	42.2	32.2	9.0	24.4	-3.3	-11.9	4.8	-1.4	5.6	16.7	14.3
64	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	-0.8	-19.1	-20.0	-6.1	-30.4	-37.9	-20.3	8.9	-41.3	-25.2	-14.4	-26.4	-37.5	-44.4	-17.1	-27.5
65	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	2.9	-2.3	0.6	2.4	-9.7	2.9	3.2	-6.3	12.1	-9.6	12.0	5.2	-9.1	-15.0	9.7	-2.6

	Байгууллагын нэр	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9	A10	A11	A12	A13	A14	A15	A16
66	Барилга, хот байгуулалтын яам	16.1	19.8	17.4	18.1	2.6	3.6	14.7	48.2	6.3	-52.4	-37.6	5.1	0.0	0.0	6.6	0.5
67	Батлан хамгаалах яам	11.2	-0.3	6.9	5.6	3.7	3.0	-3.9	52.7	-0.4	8.1	1.3	10.6	3.4	0.0	12.2	8.9
68	Боловсрол, шинжлэх ухааны яам	-53.7	-43.1	-51.4	-56.6	-64.3	-59.1	-35.1	-45.7	-54.1	-18.7	-19.1	-25.3	0.0	-7.1	-42.4	-33.0
69	Гадаад харилцааны яам	2.5	-3.9	-3.9	-13.3	1.1	-4.8	1.8	-55.8	-2.1	-13.1	-21.7	1.3	0.0	0.0	1.4	3.2
70	Зам, тээврийн хөгжлийн яам	-4.8	-20.9	-13.8	-24.4	-19.2	-18.9	-32.8	11.8	-17.5	-12.2	-26.7	-4.2	0.0	0.0	6.6	2.5
71	Сангийн яам	-2.0	-16.0	-5.2	-17.3	-10.3	-24.0	-16.3	42.7	-3.1	-10.9	-10.2	1.8	-4.3	-5.6	4.3	-0.8
72	Соёлын яам	9.3	3.8	22.8	26.1	2.3	15.2	8.3	32.2	16.5	4.2	6.0	11.8	0.0	0.0	7.0	15.0
73	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	-32.9	-23.8	-18.6	-16.0	-25.2	-44.2	-2.1	20.7	-1.8	11.4	16.8	-31.0	-47.6	-55.6	-26.7	-25.6
74	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2.3	-15.9	-12.5	-32.1	-24.2	-22.1	-11.6	-9.3	-26.9	0.7	-20.0	15.8	0.0	0.0	-3.3	2.6
75	Хууль зүй, дотоод хэргийн яам	9.7	13.1	-3.6	3.1	0.0	8.5	6.8	18.9	9.1	8.4	16.7	13.5	0.0	0.0	14.4	15.8
76	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	-13.3	-18.3	-10.0	-16.3	-11.7	-18.0	-25.9	-41.9	-19.2	-35.3	-35.1	-33.2	-4.5	-5.3	-23.3	-26.3
77	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-1.0	-3.8	5.8	-12.1	-6.1	-1.2	-13.4	-34.6	-11.0	-24.5	-32.1	-18.8	0.0	0.0	-14.6	-17.0
78	Эдийн засаг, хөгжлийн яам	-21.7	-29.5	-31.3	-21.6	-42.6	-37.4	-32.0	-43.1	-40.9	-24.0	-9.3	-15.3	-15.8	-27.8	-23.0	-13.8
79	Эрүүл мэндийн яам	-21.0	-27.0	-12.5	-15.6	-21.3	-25.0	-29.8	27.8	-23.0	-24.6	-27.2	-7.3	0.0	0.0	-11.7	-19.5
80	Эрчим хүчний яам	-41.3	-36.7	-26.0	-28.8	-49.8	-35.6	-34.1	54.7	-34.8	-18.2	-9.2	-22.9	-15.8	-17.7	-17.1	-25.7
	Дундаж	-10.7	-10.4	-4.5	-8.4	-14.1	-11.0	-10.2	6.7	-9.4	-8.2	-6.7	-4.1	-7.7	-7.5	-4.7	-4.5



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД

Энэхүү судалгааны тайланг “Авлигатай тэмцэх газар”-ын захиалгаар “Бодлогын шийдэл” ТББ бэлтгэв. Тайланд тусгагдсан мэдээлэл нь захиалагчийн өмч тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хувиан олшруулахыг хориглоно.